



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД 2019 ОНД ОРУУЛСАН
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭХЭЭР БАТЛАХ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ЯВЦ, ТӨЛӨВ**

**Улаанбаатар хот
2022 он**

ТАЛАРХАЛ

“Энэхүү бүтээлийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн Хууль зүйн сургууль болон Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн багш, судлаач оюутнуудын баг хийж гүйцэтгэв. Судалгааны ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн байгууллагуудад талархал илэрхийлье. Бүтээлд илэрхийлэгдсэн агуулга, дүгнэлт, санал нь судлаачдын үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.”

Судалгааны багийн бүрэлдэхүүн

Судалгааны багийн ахлагч:

О. Алтантуяа \МУИС - Хууль Зүйн Сургууль, Нийтийн эрх зүйн тэнхимийн багш\
Д. Бадамдаш \МУИС - Улс төр судлалын тэнхимийн багш\

Төслийн зохицуулагч:

Р. Оюундэлгэр \Төслийн зохицуулагч, судлаач, МУИС - Хууль Зүйн Сургууль, V түвшин\

Судалгааны багийн гишүүд:

Ү. Ананд \МУИС - Хууль Зүйн Сургууль, V түвшин\
Б. Баасансүрэн \МУИС - Хууль Зүйн Сургууль, V түвшин\
Г. Баярчимэг \МУИС - Улс төр судлалын магистрант\
О. Одчимэг \МУИС - Хууль Зүйн Сургууль, V түвшин\
Б. Сарантуяа \МУИС - Улс төр судлалын магистрант\
Д. Сайнбаяр \МУИС - Улс төр судлалын тэнхим, IV түвшин\
Б. Тэлгүн \МУИС - Хууль Зүйн Сургууль, III түвшин\
Э.Энхмаа \МУИС - Улс төр судлалын тэнхим, IV түвшин\
Э.Эрхбилгүүн \МУИС - Хууль Зүйн Сургууль, V түвшин\

ОРШИЛ

Монгол Улс ардчилсан, шинэ Үндсэн хуулиа 1992 оны 1 дүгээр сарын 13-нд баталж, улс, эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилго дор нэгдэж, Үндсэн хуулиа даяар олноо зарлан тунхагласнаас хойш 30 жил өнгөрчээ. Ардчилсан Үндсэн хууль боловсруулах ажлын хэсгийг анхны Ерөнхийлөгч П.Очирбат тэргүүлж, нэрт хуульч Б.Чимид нарийн бичгийн даргаар нь ажиллаж, олон намын төлөөллөөс бүрдсэн 20 гишүүнтэй комисс 1990-1992 онд судалгаа хийж, төслийг Улсын Бага Хурлаар 4 удаа, бүх нийтээр 3 сар хэлэлцүүлж, Ардын Их Хурлаар 1991 оны сүүлээр 70 гаруй хоног хэлэлцэн, шинэ Үндсэн хуулийг батлан тунхагласан юм.

1992 оны Үндсэн хуулийн хүрээнд Монгол Улсад ардчиллыг тогтоох үйл явц өрнөж, парламентын тогтолцоог сонгож, төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван салаа мөчирт хуваарилж, тэдгээрийн харилцан хяналт-тэнцлийг хангахын сацуу хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах үндэс суурийг тавьсан. Үндсэн хуулиар улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг олон улсын түвшинд тунхаглаж; үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх зэрэг эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч хүний эрхийг дээдлэх үзлийг тогтоож; хөрөнгөтэй байх, түүнийгээ захиран зарцуулах хийгээд ардчилсан сонгууль, сонгуулийн эрх, эрх чөлөөг баталгаажуулж, олон ургалч байдлыг хөгжүүлсэн зэрэг Үндсэн хуулийн тулгуур үзэл санаа, зарчмууд нь ардчиллыг чанарын хувьд шат ахиулан хөгжүүлсэн ололт амжилт билээ.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Үндсэн хууль боловсруулагчид, Үндсэн хууль тогтоогчид, судлаач, эрдэмтэд нийгмийн хөгжил, өөрчлөлтийн явцад олон сорилт бэрхшээлтэй тулгарсан ба Үндсэн хуульд оруулсан 2000 оны нэмэлт, өөрчлөлт нь иргэдийн оролцоог хангаагүй, төрийн эрх мэдэл хоорондын хяналт-тэнцлийг хангахад сөрөг үр дагавар авчирсан, Үндсэн хуульд тусгайлан заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимд нийцээгүй арга хэлбэрийг хэрэглэсэн зэргээр “дордуулсан долоон өөрчлөлт” хэмээн нэрлэгдэж шүүмжлэл дагуулж ирсэн.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүссэн тухай хууль тогтоогчид, хуульчид, эрдэмтэн судлаачид, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн дунд яригдаж Үндсэн хуулийн шинэ төсөл, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүд 2011-2019 онд ажлын хэсгийн судалгаа, зөвлөлдөх санал асуулга, бүсчилсэн хэлэлцүүлэг хэлбэрээр улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд 69 удаа зохион байгуулагдаж өргөн хүрээнд хуулийн төслийг бэлтгэн хэлэлцжээ. Эдгээр судалгаа, зөвлөлдөх санал асуулгын зөвлөмж, олон нийтийн хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал, харьцуулсан судалгааны үр дүнд хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хяналт-тэнцэл нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалын дагуу хэрэгжээгүй, улс төрийн намын үйл ажиллагаа түүний санхүүжилт, ил тод байдал хангалтгүй, байгалийн баялгийг ашиглах болон улсын хөгжил, алсын хараа, урт хугацааны бодлого нь залгамж чанар муутай, Засгийн газрын тогтвортой байдал, улс төрийн хүчин бодлогоо тууштай хэрэгжүүлэх нөхцөл бүрэн бүрдээгүй, шүүх эрх мэдлийн хараат бус, хариуцлагатай байдал суларсан, иргэдийн шүүхэд итгэх итгэл буурсан, Үндсэн хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хараат бус, хариуцлагатай байх эрх зүйн орчин бүрдээгүй, нутгийн удирдлагын тогтолцоог зохих ёсоор бэхжүүлэх хэрэгцээ шаардлага нийгмийн хөгжлийн явцад зайлшгүй үүссэн гэх зэрэг үндэслэлээр хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулан 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн 19 зүйл, 36 хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулсан. 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн дөрвөн бүлгийн хүрээнд хамаарах нэмэлт, өөрчлөлтүүд орж дагалдах хууль тогтоомжоор 31 багц хуулийн төсөл боловсруулагдахаар тусгажээ.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс хойш даруй 2 жил өнгөрсөн байгаа энэ цагт иргэдийн дунд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бүрэн танилцуулах, дагалдах хууль тогтоомжийн ойлголт, хэрэглээг цэгцлэн таниулах, иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, Улсын Их Хурлаас батлан гарах хуулиуд Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, хэрэгжилт ямар байгаа талаар дүгнэлт хийх, эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх шаардлага үүссэн тул Азийн сан болон МУИС – ийн Хууль зүйн сургууль, Шинжлэх Ухааны Сургуулийн, Улс төр судлалын тэнхим нар хамтран цуврал судалгааг хийж гүйцэтгэж байна. Эхний судалгааны ажлаар “Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн дүн шинжилгээ” судалгааг хүргүүлсэн бол энэхүү хоёр дахь судалгааны ажлаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 1-р сарын 9-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт,

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэхээр батлах хууль тогтоомжийн явц, төлөв өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэхээр батлах хууль тогтоомжийн төлөв явцын судалгааг бэлтгэн хүргүүлж байна.

АГУУЛГА

I. “МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ”-Д ХОЛБОГДОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭН ГАРАХ ХУУЛЬ ТОГТООМЖУУДАД ХИЙСЭН СУДАЛГАА	4
НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ	4
ХОЁР. ХУУЛЬ	6
2.1. ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ	6
2.2. ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдсан/	7
2.3. АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдаагүй/	8
2.4. ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдаагүй/	9
ГУРАВ. ЭРХ ЗҮЙН АКТ	10
ДӨРӨВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ	11
II. “ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ”-Д ХОЛБОГДОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭН ГАРАХ ХУУЛЬ ТОГТООМЖУУДАД ХИЙСЭН СУДАЛГАА	12
НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ	12
ХОЁР. ХУУЛЬ	12
2.1. ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдаагүй/	12
2.2. АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдаагүй/	12
ГУРАВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ	13
III. “ХУУЛЬ ТОГТООХ ЭРХ МЭДЭЛТЭЙ” ХОЛБОГДОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭН ГАРАХ ХУУЛЬ, ТОГТООМЖИД ХИЙХ СУДАЛГАА	15
НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ	15
ХОЁР. ХУУЛЬ	16
2.1. ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА	16
2.2. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛЬ	24
2.3. АНХДАГЧ ХУУЛЬ	27
2.4. УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	27
ГУРАВ. ЭРХ ЗҮЙН АКТ	28
3.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ	28
ДӨРӨВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ	29
IV. “ГҮЙЦЭТГЭХ ЭРХ МЭДЭЛ”-Д ХОЛБОГДОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭН ГАРАХ ХУУЛЬ ТОГТООМЖУУДАД ХИЙСЭН СУДАЛГАА	33
НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ	33
ХОЁР. ХУУЛЬ	31
2.1. ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА	38
2.2. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛЬ	39
2.3. УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	41
ГУРАВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ	42
V. ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАЖ, ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ	48
НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ	48
ХОЁР. ХУУЛЬ	44
2.1. ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА	44
2.2. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛЬ	46
2.3. УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	46
ГУРАВ. ЭРХ ЗҮЙН АКТ	46
3.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ	46
ДӨРӨВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ	48
VI. “ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА”-Д ХОЛБОГДОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭН ГАРАХ ХУУЛЬ, ТОГТООМЖИД ХИЙСЭН СУДАЛГАА	56
НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ	56
ХОЁР. ХУУЛЬ	58
2.1. ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА	59
2.2. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛЬ	63
2.3. УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДСАН ХУУЛИЙН ТӨСӨЛ	72
ГУРАВ. ЭРХ ЗҮЙН АКТ	76
3.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ	76
ДӨРӨВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ	78
ДҮГНЭЛТ	92
ЭХ СУРВАЛЖ	94

I. “МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ”-Д ХОЛБОГДОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭН ГАРАХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХИЙСЭН СУДАЛГАА

НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга хийгдээгүй тул холбогдох хуулиудын нэмэлт, өөрчлөлт, анхдагч хуулийн төсөл боловсруулагдсан эсэх талаар дараах хүснэгтэд оруулав.

ХУУЛЬ		
Нэг.	УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДСАН ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ	
№	Төслийн нэр	Өргөн баригдсан хугацаа
1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль ¹	2021 оны 05 сарын 19-ны өдөр
Хоёр	УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДСАН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ	
№	Төслийн нэр	Өргөн баригдсан хугацаа
1	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ²	Тодорхойгүй
2	Улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр
3	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр
4	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр
5	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр
6	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр
7	Харилцаа холбооны тухай хуулийн зарим зүйл заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр
8	Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр
9	Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр
10	Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр

¹ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн төсөл, <http://forum.parliament.mn/projects/11114> [Сүүлд үзсэн: 2022.03.22]

² Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, <http://forum.parliament.mn/projects/11204> [Сүүлд үзсэн: 2022.03.22]

11	Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр
12	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр
13	Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2021 оны 05 сарын 19-ны өдөр
Гурав	УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛ	
№	Төслийн нэр	Бичигдсэн хугацаа
1	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл ³	Тодорхойгүй
2	Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл	Тодорхойгүй
Дөрөв	УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ⁴	
№	Төслийн нэр	Бичигдсэн хугацаа
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Тодорхойгүй
2	Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Тодорхойгүй
3	Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Тодорхойгүй
4	Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Тодорхойгүй
ЭРХ ЗҮЙН АКТ		
Нэг	Улсын Их Хурлын тогтоолын төсөл	
№	Төслийн нэр	Бичигдсэн хугацаа
1	Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Тодорхойгүй

ХОЁР. ХУУЛЬ

2.1. ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

Хуулийн нэр	Өргөн баригдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
-------------	-------------------------	---------------------------------

³ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, (shorturl.at/nCDRW) [Сүүлд үзсэн: 2022.03.22]

⁴ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг даган дээрх хуулийн төслүүд гарсан.

<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль \шинэчилсэн найруулга\</p>	<p>2021 оны 05 сарын 19-ны өдөр</p>	<p>Тус хуулиар хуульд заасан үндэслэл журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийг бий болгох замаар төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зэрэг харилцааг зохицуулахаар байна.</p>
---	-------------------------------------	--

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсэгт “...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй...” хэмээн тусгагдсан. Энэ нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл хүлээн авах эрхийн тухай хууль /МИТБМХАЭТХ/-д нэмэлт өөрчлөлт оруулахаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 1-р сарын 9-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсан. Харин Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /НМИТБТХ/ батлагдсанаар МИТБМХАЭТХ хүчингүй болохоор байна.

НМИТБТХ хуулийн төсөлд:

- 8.6.9.хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл;
- 8.6.10.мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;
- 8.6.9. хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл;
- 8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;
- 8.6.9. хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл;
- 8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; гэх зохицуулалтууд орсноор төрийн болон төрийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдүүдийн байгаль орчны ашиглалтаас үүсэх үр дагаврын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах арга зохицуулжээ.

2.2. ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдсан/

Хуулийн төслийн нэр	Өргөн баригдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	2021 оны 11 сарын 24-ны өдөр	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 1 зүйл, 3 хэсгээс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрх болон иргэний тус эрхийг аймаг нийслэл, сум дүүргийн Засаг дарга хангаж, иргэнд мэдээлэл өгөх асуудлыг тодорхой болгож тусгана.
<p align="center">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд энэхүү нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсэгт “...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй...” хэмээн тусгасан.</p> <p>Энэ нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхийг бататгах нь төрийн үндсэн үүрэг байна.</p> <p>Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд байгаль орчныг хамгаалах талаар иргэний мэдэх эрхийг хуульчилсан бөгөөд энэхүү хэсэгт хуулийн нэмэлт оруулах хуулийн төслөөр иргэний мэдэх эрхийг баталгаажуулан нэмэхээр боловсруулсан байна. Мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга байгаль орчны төлөв байдлыг иргэдийн хуралд тайлагнах бүрэн эрхийг зохицуулсан байна. Харин аж ахуй нэгж, байгууллагын мэдээлэх үүрэгтэй холбогдсон зохицуулалт төсөлд тусгагдаагүй байна.</p>		

2.3. АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдаагүй/

Хуулийн төслийн нэр	Өргөн баригдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл	Тодорхойгүй	Үндэсний баялгийн сангийн төрлийг тогтоож, тус сангийн удирдлагыг хэрэгжүүлэхэд баримтлах нийтлэг зарчим, сангийн тайлагнал, ил тод байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.
<p align="center">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж тусгасан. Энэхүү нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийн төслийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас боловсруулсан байна. Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн⁵ 23 дугаар зүйлд заасны дагуу анхдагч хуулийн төсөлд хамаарах бөгөөд үндсэн 3 бүлгээс бүрдэх бөгөөд тус хуулийн зорилго нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлж тэгш, шударга хүртээх Үндэсний баялгийн санг байгуулах Хөгжлийн сан болон Ирээдүйн өв санд баримтлах нийтлэг зарчим, сангийн ил тод байдал, тайлагнал, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна.</p>		

⁵ Хууль тогтоомжийн тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/11119>

<ul style="list-style-type: none"> • Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагаанд баримтлах нийтлэг зарчим, Үндэсний баялгийн сан, түүний төрлийн талаар; • Хоёрдугаар бүлэгт Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн удирдлагад тавигдах нийтлэг шаардлага; • Гуравдугаар бүлэгт Үндэсний баялгийн сангийн тайлагнал, ил тод байдал, хариуцлага хүлээлгэх үндэслэл, хууль хүчин төгөлдөр болохтой холбоотой асуудлыг тус тус зохицуулахаар тусгагдсан байна. <p>Баялгийн сан нь “Ирээдүй өв сан”, “Хөгжлийн сан” гэх төрөлтэй бөгөөд үйл ажиллагаандаа хараат бус, бие даасан, ил тод, зохистой удирдах, үр ашигтай байх, хариуцлагатай байх зарчмыг баримтлана. Мөн сангийн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжтэй байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс удирдлагын нийтлэг шаардлагыг тусгаж өгсөн байна.</p>		
Хуулийн төслийн нэр	Өргөн баригдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Хөгжлийн сангийн тухай	Тодорхойгүй	Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, дотоодын төсөлд санхүүгийн үр ашигтай хөрөнгө оруулалт хийх замаар хөрөнгийг арвижуулах, хөгжлийн санг байгуулах, сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хөрөнгийг удирдах, хуваарилах, хөгжлийн сангийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна.
<p align="center">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх талаар зохицуулсан бөгөөд үүнтэй холбогдуулан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төслөөр төрлийг тогтоож, тус сангийн удирдлагыг хэрэгжүүлэхэд баримтлах нийтлэг зарчим, сангийн тайлагнал, ил тод байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулахаар боловсруулсан. Харин Хөгжлийн сангийн тухай хуулиар сангийн хөрөнгө, эх үүсвэр, эрх зүйн байдалтай холбоотой харилцааг зохицуулахаар тусгагдсан байна.</p>		

2.4. ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдаагүй/

Хуулийн төслийн нэр	Өргөн баригдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	тодорхойгүй	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Ирээдүйн өв сан корпорацын” гэснийг “Ирээдүйн өв сангийн корпорац, Хөгжлийн сан, түүний хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн” гэж өөрчлөхөөр боловсруулсан байна.
<p align="center">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар</p>		

<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндэсний баялгийн сангийн тухай зохицуулалт тусгагдсан бөгөөд Үндэсний баялгийн сангийн тухай хуульд баялгийн санг Ирээдүй өв сөн, Хөгжлийн сан хэмээн ангилсан. Үүнтэй холбогдуулан төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд Хөгжлийн сангийн эрх зүйн байдалтай холбогдох зохицуулалтыг тусгасан байна.</p>		
Хуулийн төслийн нэр	Өргөн баригдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	тодорхойгүй	Зөрчлийн тухай хуулийн 9.8 дугаар зүйлийн “Ирээдүйн өв сангийн тухай хууль зөрчих” гэснийг “Үндэсний баялгийн сангийн тухай, Ирээдүйн өв сангийн тухай, Хөгжлийн сангийн тухай хууль зөрчих” гэж өөрчлөхөөр төсөлд тусгагдсан байна.
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар</p> <p>Сангийн үйл ажиллагаа, зорилго нь одоо ба ирээдүй үр хойчид зориулагдах Үндсэн хуулийн үзэл баримтлалаар Үндэсний баялгийн сангийн тухай, Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулагдсан бөгөөд хуульд заасан зарчим, хөрөнгийн удирдлагыг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээхээр Зөрчлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөлд тусгагдсан байна.</p>		
Хуулийн төслийн нэр	Өргөн баригдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	тодорхойгүй	Сангийн эх үүсвэрийн нэг нь Хөгжлийн сангийн ногдол ашиг байхаар зохицуулсан байна.
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар</p> <p>Нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Ирээдүй өв сангийн үйл ажиллагаа явагдах бөгөөд энэхүү сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, байгалийн баялгийн ашиглалтаас бий болсон Хөгжлийн сангийн ногдол ашгаас Ирээдүй өв сан руу шилжүүлэхээр зохицуулсан байна.</p>		
Хуулийн төслийн нэр	Өргөн баригдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	тодорхойгүй	Хөгжлийн сангийн орлогын эх үүсвэрийг татвараас чөлөөлөхөөр зохицуулсан байна.
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар</p> <p>Хөгжлийн сангийн тухай хуульд заасан “9.1.1.Засгийн газраас Хөгжлийн сангийн эзэмшилд шилжүүлсэн хөрөнгө; 9.1.2.Хөгжлийн сангийн хөрөнгөд бүртгэлтэй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой</p>		

хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг; 9.1.3.Хөгжлийн сангийн хөрөнгөд бүртгэлтэй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчид хамаарах хувьцааг борлуулсны орлого; 9.1.4.Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас олох ашиг; 9.1.5.Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт хийсэн хуулийн этгээдийг өөрчлөн байгуулсны үндсэн дээр бий болсон ашиг” эдгээр орлогуудыг аж ахуй нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхөөр зохицуулсан байна.

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН АКТ

Тогтоолын нэр	Өргөн баригдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Тодорхойгүй	Тогтоолын төсөлд “Эрдэнэс Монгол” ХХК-ийг Хөгжлийн сан ХХК болгож үйл ажиллагааг зохион байгуулах, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн төрийн өмчийн хувьцааг Хөгжлийн сан ХХК-д шилжүүлж, холбогдох бүртгэлийг хийлгэхийг зохицуулсан байна.

ДӨРӨВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нэмэлт орсон бөгөөд үүнтэй холбогдуулан Монгол улсын хууль тогтоомжуудад заасан төрийн өмчийн зохицуулалтуудыг “төрийн нийтийн өмч” болгон өөрчлөх, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг батлах, байгалийн баялгийг ашиглах, баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг баталгаажуулах зэрэг асуудлуудыг хууль тогтоомжуудад тусгах шаардлага үүссэн.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 сарын 09-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсан бөгөөд уг хуваариар Үндсэн хуулийн 6.2-д орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан хууль тогтоомжуудыг өөрчлөхөөр тусгасан. Уг хуваарийн дагуу 7 хууль болон түүнтэй холбогдох бусад хууль тогтоомжийн шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлт, анхдагч хуулийг 2020 онд батлахаар төлөвлөсөн ч өнөөдрийн байдлаар Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Үндэсний баялгийн санд холбогдох хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиуд болон тэдгээрт холбогдох хуульд, нийт 20 хуулийн нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга, анхдагч хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

II. “ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ”-Д ХОЛБОГДОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭН ГАРАХ ХУУЛЬ ТОГТООМЖУУДАД ХИЙСЭН СУДАЛГАА

НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ

ХУУЛЬ		
Нэг	ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдаагүй/	
№	Хуулийн нэр	Өргөн баригдах хугацаа
1	Улс төрийн намын тухай хууль \шинэчилсэн найруулга\	2022 оны хаврын чуулганаар хэлэлцэнэ.
Хоёр	АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдаагүй/	
№	Төслийн нэр	Өргөн баригдах хугацаа
1	Улс төрийн санхүүжилтийн тухай хууль \анхдагч хууль\	Тодорхойгүй

ХОЁР. ХУУЛЬ

2.1. ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдаагүй/

Хуулийн нэр	Өргөн баригдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Улс төрийн намын тухай хууль \шинэчилсэн найруулга\	2022 оны Хаврын чуулганд хэлэлцэхээр хүлээгдэж байна.	Намын чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаа хууль дээдлэх зарчимд суурилсан байх; Улс төрийн намын хариуцлагын тогтолцоог тодорхой болгох; Сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэний дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах журмыг тогтоох.
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд улс төрийн намын чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаа зэрэг нь хууль дээдлэх зарчимд суурилсан байх хийгээд улс төрийн намын хариуцлагыг нэмэгдүүлэх, улс төрийн нам байгуулах журмыг шинэчлэн тогтоох, нам үндэсний хэмжээнд бодлого дэвшүүлэн ажиллах зэрэг агуулга бүхий нэмэлт өөрчлөлтүүд орж улс төрийн намын үйл ажиллагаа, хариуцлагыг нэмэгдүүлнэ гэж үзэж байна.</p>		

2.2. АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛ /Улсын Их Хуралд өргөн баригдаагүй/

Хуулийн төслийн нэр	Өргөн баригдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Улс төрийн санхүүжилтийн тухай хууль \анхдагч хууль\	Тодорхойгүй	Улс төрийн намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нийтэд ил тод байх; Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох;
<p align="center">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсан бөгөөд хавсралтын “1.4. Улс төрийн намтай холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:” хэмээн тусгаад 1.4.4-т “намын санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт, тайлан нь олон нийтэд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;” гэсэн чиглэл орсны дагуу Улс төрийн намын санхүүжилтийн асуудлыг Улс төрийн намын тухай хуулиар зохицуулах эсэх, Улс төрийн санхүүжилтийн тухай анхдагч хууль батлах эсэх дээр суурь судалгаанууд хийгдэж УИХ-ын 2022 оны хаврын чуулганаар хэлэлцэхээр хүлээгдэж байна. Улс төрийн санхүүжилтийн тухай хуулийн төсөлд шинэчлэгдэн батлагдах төлөвтэй “Улс төрийн намын тухай” хуулиар зохицуулагдсан хийгээд дэлгэрүүлэн зохицуулагдах шаардлагатай намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зохицуулалт, намын гишүүдийн татвар, иргэдийн хандив, хуулийн этгээдийн хандив, намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого зэргийг зохицуулан тусгахаар төлөвлөж байгаа бөгөөд улс төрийн намын сонгуульд нэр дэвшүүлж санал авах боломжит хөгжлийн бэрхшээлтэй болон эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог үнэлсэн санхүүгийн дэмжлэгийн шинээр тусгаж байгаа зэргээрээ онцлогтой хуулийн төсөл боловсруулагдаж байна.</p>		

ГУРАВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Монгол улс 1992 онд ардчилсан, шинэ Үндсэн хуулиа баталснаар Монгол Улсад олон намын тогтолцоо бүрэлдэн бий болжээ. Улс төрийн намын тухай хууль нь 1990 оны 5 дугаар сарын 10-нд анхлан батлагдаж, 2005 оны 1 дүгээр сарын 28-ний өдөр шинэчлэгдэн батлагдсан ба 2005 онд 1 удаа, 2015 онд 3 удаа, 2019 онд 1 удаа, 2020 онд 1 удаа тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Үүний дараагаар Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурал (УИХ)- д 2019 оны 6 дугаар сарын 6-нд өргөн барьсан бөгөөд 11 дүгээр сарын 14-нд баталсан. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэг болох “Хүний эрх, эрх чөлөө” хэсгийн 19-р зүйлд “Арван ес дүгээр зүйл” -ийг нэмэлт өөрчлөлтөөр нэмсэн байна. Энэ хэсэгт Монгол Улсад Улс төрийн нам байгуулагдах хийгээд нам нь улсын хэмжээнд бодлого дэвшүүлж ажиллах, намыг эвлэлдэн нэгдэж байгуулах тухай мөн намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтоохоор заасан. Үндсэн хуулийн энэхүү нэмэлттэй холбогдуулан 2005 оны “Улс төрийн намын тухай” хуулийг шинэчлэн найруулах, “Улс төрийн санхүүжилтийн тухай” анхдагч хуулийн боловсруулах шаардлага, хэрэгцээ үүсэж “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-г төлөвлөсөн байна.

“Улс төрийн намын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд намын санхүүжилтийн эх үүсвэрийг 5 болгож цөөрүүлсэн боловч төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг маш дэлгэрэнгүй байдлаар зохицуулж өгсөн байна. Санхүүгийн дэмжлэгийг шууд болон шууд бус гэж ангилж авч үзсэн. Санхүүгийн шууд дэмжлэг гэдэг нь УИХ-ийн сонгуульд нийт сонгогчдын 3-аас дээш хувийн санал авах үр дүнд тулгуурлахаар болсон хийгээд намын чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаа зэрэг нь хууль дээдлэх зарчимд суурилсан байх хийгээд улс төрийн намын хариуцлагыг нэмэгдүүлэх, улс төрийн нам байгуулах журмыг шинэчлэн тогтоох, нам үндэсний хэмжээнд бодлого дэвшүүлэн ажиллах зэрэг агуулга бүхий нэмэлт өөрчлөлтүүд орж улс төрийн намын үйл ажиллагаа, хариуцлагыг нэмэгдүүлнэ

гэж үзэж байна. Мөн төрийн болон төрийн бус холимог санхүүжилтийн зарчмыг хэвээр хадгалах боловч, эх үүсвэр, хэмжээ, хуваарилалт, санхүүжилтийн зарчим, зарцуулалтын зориулалтыг хуульд илүү нарийвчлан тусгах тухай “Улс төрийн намын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Бодлогын цахим хэлэлцүүлэгт дурджээ.

“Улс төрийн санхүүжилтийн тухай” анхдагч хуулийн төслийн хувьд Улс төрийн намын тухай хуулиар батлагдах намын санхүүжилтийн арга, хэлбэрүүдийг илүү дэлгэрүүлэн тусгахаас гадна зөвхөн намын санхүүжилт бус улс төрийн бүх төрлийн санхүүжилтийн асуудлыг тусгаж хуулийн төсөл боловсруулахаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-г төлөвлөсөн байна. Тухайлбал:⁶

- “Нийт сонгогчийн тоог хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувиар үржүүлснээс илүүгүй төгрөгийг улсын төсвөөс намуудад энэ хуульд заасны дагуу жил бүр хуваарилна.
- Намд үзүүлэх санхүүгийн шууд дэмжлэг нь сүүлийн сонгуулиар Улсын Их Хуралд авсан суудал болон нийт сонгогчийн 3-аас дээш хувийн санал авсан үр дүнд тулгуурлана.
- Улсын Их Хурлын сонгуулиас бусад сонгуулийн үр дүнгээр улсын болон орон нутгийн төсвөөс намд санхүүжилт олгохыг хориглоно.
- Төр нь санхүүгийн шууд бус дэмжлэгийг намд сонгуулийн үед хуульд заасны дагуу үзүүлнэ.
- Эрх үүсэх жилд төрийн санхүүгийн дэмжлэг авах зорилгоор уул дэмжлэгийн хэмжээг тогтоолгох, дэмжлэг олгохыг хүссэн хүсэлтээ нам тухайн жилийн өмнөх жилийн 8 дугаар сарын 15-аас өмнө сонгуулийн төв байгууллагад гаргана.
- Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллага энэ хуульд заасны дагуу намд олгох төсвийн хөрөнгийг зөв тогтоож олгосон эсэхийг нягтлан шалгана” гэх мэт зохицуулалтыг оруулахаар төлөвлөжээ.

⁶ “Улс төрийн намын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл 2021 он

III. “ХУУЛЬ ТОГТООХ ЭРХ МЭДЭЛТЭЙ” ХОЛБОГДОХ НЭМЭЛТ,ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭН ГАРАХ ХУУЛЬ, ТОГТООМЖИД ХИЙХ СУДАЛГАА

НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс хойш шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон, хараахан батлагдаагүй боловч хуулийн төслүүд зэрэг эрх зүйн хэм хэмжээний актуудыг доорх хүснэгтэд оруулав.

ХУУЛЬ		
Нэг	ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА	
№	Хуулийн нэр	Батлагдсан хугацаа
1	Монгол Улсын Их Хурлын тухай хууль ⁷	2020 оны 05 сарын 07-ны өдөр
2	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль ⁸	2019 оны 12 сарын 19-ны өдөр
3	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль ⁹	2020 оны 05 сарын 07-ны өдөр
4	Төрийн аудитын тухай хууль ¹⁰	2020 оны 05 сарын 01-ны өдөр
5	Монгол улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль ¹¹	2020 оны 05 сарын 13-ны өдөр
Хоёр	НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ	
№	Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт оруулсан хугацаа
1	Төсвийн тухай хууль	2020 оны 05 сарын 01-ны өдөр
2	Зөрчлийн тухай хууль	2020 оны 12 сарын 21-ны өдөр
3	Нийтийн сонсголын тухай хууль	2021 оны 12 сарын 24-ны өдөр
4	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	2021 оны 12 сарын 24-ны өдөр
5	Эрүүгийн хууль	2021 оны 12 сарын 24-ны өдөр
Гурав	АНХДАГЧ ХУУЛЬ	
№	Хуулийн нэр	Батлагдсан хугацаа

⁷ Монгол Улсын Их Хурлын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/15441>

⁸ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/14869>

⁹ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/15403>

¹⁰ Төрийн аудитын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/15357>

¹¹ Монгол улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/15412>

1	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль ¹²	2021 оны 12 сарын 24-ны өдөр
Дөрөв	УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	
№	Төслийн нэр	Бичигдсэн хугацаа
1	Ерөнхийлөгчийн тухай хууль ¹³	2021 оны 04 сарын 26-ны өдөр
ЭРХ ЗҮЙН АКТ		
Нэг	УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ	
№	Тогтоолын нэр	Батлагдсан хугацаа
1	Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай ¹⁴	2020 оны 08 сарын 20-ний өдрийн 24 дүгээр тогтоол

ХОЁР. ХУУЛЬ

2.1. ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

Хуулийн нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль	2019 оны 12 сарын 20-ны өдөр	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах үндсэн зарчим, журмыг тодорхойлж, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад оршино.
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай ҮНДСЭН ХУУЛИЙН 21 ДҮГЭЭР ЗҮЙЛ 21.4		
<p>Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх Улсын их хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор органик хууль болох Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглоно гэж тодорхой заасан. Уг заалтыг хэрэгжилтийг хангахын тулд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 19 ний өдөр батлагдсан бөгөөд тус хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх нэг жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно” гэж заасан буюу Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх нэг жилийн хугацаа буюу сонгуулийн санал авах өдрөөс өмнөх нэг жил гэж Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг нарийвчилж зохицуулсан.</p>		
Хуулийн нэр	Батлагдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Монгол Улсын Их хурлын тухай хууль	2020 оны 05 сарын 07-ны өдөр	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурал /цаашид "Улсын Их Хурал" гэх/-ын бүрэн эрх, түүний зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүн, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, халдашгүй

¹² Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390162361921>

¹³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, (shorturl.at/kpyDE) [Сүүлд үзсэн: 2022.03.22]

¹⁴ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, <https://legalinfo.mn/mn/detail/15586>

		байдал, түүний баталгаа, Улсын Их Хурлын үйл ажиллагааны журмыг тогтооход оршино.
<p style="text-align: center;">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>ҮНДСЭН ХУУЛИЙН 22-Р ЗҮЙЛИЙН 22.2-Т ЗААСАН ЗААЛТ</p> <p>Улсын их хурлын тухай хуулийн 36-р зүйлийн 36.1 болон 36.2-т дээрх Үндсэн хуулийн заалтыг нарийвчилж зохицуулсан байна.</p> <p>Улсын их хурлын тухай хуулийн 36-р зүйлийн 36.1-т дараах тохиолдолд Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрх энэ хуулийн 35.1-д заасан хугацаанаасаа өмнө дуусгавар болно:</p> <ul style="list-style-type: none">• Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж хугацаанаасаа өмнө тарах тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол;• Ерөнхийлөгч Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэн Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн Улсын Их Хурал хугацаанаас өмнө тарах тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол Улсын их хурлын тухай хуулийн 36-р зүйлийн 36.2-т энэ хуулийн 36.1.1, 36.1.2-т заасан тогтоолын төслийг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол Улсын Их Хурлын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох тухай тогтоол баталсанд тооцно. <p>Үндсэн хуулийн 22-р зүйлийн 22.3-т заасан заалт</p> <p>Улсын их хурлын тухай хуулийн 36-р зүйлийн 36.3-т дээрх Үндсэн хуулийн заалтыг нарийвчлан зохицуулсан байна.</p> <p>Ерөнхийлөгч дараах тохиолдолд Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана:</p> <ul style="list-style-type: none">• Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш 45 хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол;• Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас хойш 30 хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол;• Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш 30 хоногийн дотор Улсын Их Хурал шинэ Ерөнхий сайдыг томилоогүй бол. <p>ҮНДСЭН ХУУЛИЙН 22-Р ЗҮЙЛИЙН 22.4-Т ЗААСАН ЗААЛТ</p> <p>Улсын их хурлын тухай хуулийн 36-р зүйлийн 36.4 болон 36.5-т дээрх Үндсэн хуулийн заалтыг нарийвчлан зохицуулсан байна.</p> <p>Улсын их хурлын тухай хууль 36-р зүйлийн 36.4</p> <p>Энэ хуулийн 36.1, 36.2-т заасан шийдвэр гарснаас хойш Улсын Их Хурал 10 хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж, 60 хоногийн дотор сонгууль явуулна. Шинээр бүрдсэн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.</p> <p>Улсын их хурлын тухай хууль 36-р зүйлийн 36.5</p> <p>Улсын Их Хурал өөрөө тарах бол тогтоол, Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах бол зарлиг гаргах бөгөөд эдгээр шийдвэр эцсийнх байна.</p> <p>ҮНДСЭН ХУУЛИЙН 25 ДУГААР ЗҮЙЛИЙН 25.1.6</p> <p>Улсын их хурлын тухай хуулийн</p> <p>23.2.8.Улсын Их Хурлаас томилдог албан тушаалтныг томилох, чөлөөлөх, огцруулах асуудлаар санал, дүгнэлт гаргах;</p> <p>24.1.5.Гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудал;</p>		

ҮНДСЭН ХУУЛИЙН 25-Р ЗҮЙЛИЙН 25.1.7-Т ЗААСАН ЗААЛТ

Улсын их хурлын тухай хуулиар Үндсэн хуулийн 25.1.7-ны “Төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;

Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна” гэсэн хэсгүүдийг нарийвчлан зохицуулсан байна.

Улсын их хурлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.1.5-т “Төрийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, улсын төсвийг хэлэлцэн батлахад Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан хүрээнд санал гаргах” гэж зааж Улсын Их Хурал нь төрийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, улсын төсөвтэй холбоотой асуудлаар санал хүргүүлэх тохиолдолд Үндсэн хуулийн 25-р зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан хүрээнээс давсан санал гаргах боломжгүй. Мөн хуулийн 38-р зүйлийн 38.3-т “Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Засгийн газар санаачилна” буюу хараар тодруулсан хэсэгт заасан асуудалд хамаарах төслийг Засгийн газар санаачилж, Улсын их хурал батлах чиг үүрэг болохыг баталгаажуулсан байна.

Түүнчлэн, Улсын Их Хурал Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн батлахдаа Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн байх шаардлагыг хангуулна гэж хуульчилж Үндсэн хуулийн уг заалтыг органик хуулийн хүрээнд баталгаажуулсан байна.

Улсын их хурлын тухай хуулийн 24-р зүйлд байнгын хороодын эрхлэх асуудлын талаар зохицуулсан байгаа бөгөөд Үндсэн хуулийн 25-р зүйлийн 25.1.7 дэх хэсэгт хамаарах асуудал нь төсвийн байнгын хороо болон эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудал болгон хуульчилсан байна. Тус байнгын хороодын эрхлэх асуудлыг дэлгэрүүлэн авч үзвэл:

Төсвийн байнгын хороо:

- Улсын нэгдсэн төсөв, түүний гүйцэтгэл, хяналт;
- Төрийн санхүү, зээлийн болон татварын бодлого;
- Аудитын асуудал;
- Гадаад улс, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээ, хэлцэл;
- Засгийн газрын тусгай сангийн нэгдсэн бодлого;
- Улсын Их Хурлын төсөв;
- Төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Засгийн газраас гаргах үнэт цаасны тухай асуудал.

Төсвийн байнгын хороонд Төсвийн зарлагын хяналтын дэд хороо байхаар хуульд тусгасан ба тус дэд хороо нь улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн хяналтын асуудлыг эрхлэн хариуцна. Түүнчлэн тус хороо өөрийн эрхлэх асуудлаар гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд бие даан оруулна.

Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхын саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно.

Эдийн засгийн байнгын хороо: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг хариуцаж ажиллана.

Эдийн засгийн дэд хороонд Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо байхаар хуульд тусгасан бөгөөд тус дэд хороо нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг хууль тогтоомж болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлэх асуудлыг эрхлэн хариуцах ажээ.

ҮНДСЭН ХУУЛИЙН 25-Р ЗҮЙЛИЙН 25.1.16-Т ЗААСАН ЗААЛТ

Улсын их хурлын тухай хуулийн 24-р зүйлийн 24.7 дахь хэсгийн 24.7.8-т Төрийн байгуулалтын хорооны эрхлэх асуудлын нэг нь ард нийтийн санал асуулга гэж заасан байна.

Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд Улсын Их хурлын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлуудыг заасан байдаг бөгөөд тус зүйлийн 1 дэх хэсгийн 16-т ард нийтийн санал асуулга явуулах бүрэн эрх Улсын Их Хуралд хадгална.

Улсын их хурлын тухай хуульд дээрх асуудлыг Төрийн байгуулалтын хорооны эрхлэх асуудлын нэг гэж нарийвчилж зохицуулсан байна.

ҮНДСЭН ХУУЛИЙН 26 ДУГААР ЗҮЙЛ 26.1

Монгол Улсын Их Хурлын тухай хууль нь 7 бүлэг, 51 зүйлтэй. Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолын хүрээнд шинэчилсэн найруулгыг хийсэн.

Тус хуулийн 38 дугаар зүйлд Хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг тодорхойлж өгсөн байна.

- Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачилна.
- Ерөнхийлөгч энэ хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3-т зааснаас бусад асуудлаар хууль санаачилна. Ерөнхийлөгч хууль санаачлахдаа Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийг баримтална.
- Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Засгийн газар санаачилна.

ҮНДСЭН ХУУЛИЙН 27 ДУГААР ЗҮЙЛ 27.2

Улсын их хурлын тухай хуулийн 18 дугаар зүйлд ээлжит чуулгантай холбоотой дараах зохицуулалтуудыг заасан байна. Үүнд:

18.1.Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган 10 дугаар сарын 01-ний өдрөөс, хаврын ээлжит чуулган 3 дугаар сарын 15-ны өдрөөс тус тус эхлэн 75-аас доошгүй ажлын өдөр чуулна.

18.2.Ээлжит чуулганыг нээх өдөр амралт, баяр ёслолын өдөртэй давхацвал дараагийн ажлын өдөр нээнэ.

18.3.Онцгой нөхцөл үүссэн бол ээлжит чуулганы нээлтийг хойшлуулах асуудлыг Зөвлөлөөр хэлэлцэн Улсын Их Хурлын дарга захирамж гаргаж шийдвэрлэнэ.

18.4.Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурал урьдчилан хэлэлцэж тогтоол гаргах бөгөөд ээлжит чуулган эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын дарга ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож захирамж гаргана.

18.5.Ээлжит чуулганыг нээж, хааж Улсын Их Хурлын дарга үг хэлнэ гэх байдлаар дэлгэрэнгүй зохицуулсан байна

ҮНДСЭН ХУУЛИЙН 27 ДУГААР ЗҮЙЛИЙН 27.6,7

Монгол улсын Их хурлын тухай хууль

37.3 Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хуулийг эцэслэн батална.

37.4.Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол нууц санал хураалт явуулна.

ҮНДСЭН ХУУЛИЙН 28 ДУГААР ЗҮЙЛ 28.2

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлд Хянан шалгах түр хороог тодорхойлж өгчээ.
30.1. Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор хойшлуулахгүйгээр байгуулна.

Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурлын тухай хуулийн 23-29 дугаар зүйл хүртэл маш дэлгэрэнгүй зохицуулсан.

ҮНДСЭН ХУУЛИЙН 29 ДУГААР ЗҮЙЛ 29.3

Монгол Улсын Их Хурлын тухай хууль

9 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх

9.1. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг дараах тохиолдолд түдгэлзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ:

9.1.1. Гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт нотлох баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;

9.1.2. Гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан.

10 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох

10.1.5. Үндсэн хуулийн цэц гишүүнийг энэ хуулийн 7.2-т заасан тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн;

10.1.6. Гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон;

10.2. Энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан тохиолдолд гишүүнийг чөлөөлөх, энэ хуулийн 10.1.4, 10.1.6-д заасан тохиолдолд эгүүлэн татах тогтоол гаргах бөгөөд энэ хуулийн 10.1.5-д заасан тохиолдолд гишүүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ. Энэ хуулийн 10.1.1, 10.1.7-д заасан тохиолдолд орон гарсан гэж үзэж энэ тухай Улсын Их Хурлаас шийдвэр гаргахгүй.

10.3. Гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, энэ хуулийн 10.1.4, 10.1.5-д заасан асуудлаар гишүүн саналаа нууцаар, энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.6-д заасан асуудлаар гишүүн саналаа илээр гаргана. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татахыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.

Хуулийн нэр	Батлагдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Төрийн аудитын тухай хууль	2020.05.01	Энэ хуулийн зорилго нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай

ҮНДСЭН ХУУЛИЙН 25-Р ЗҮЙЛИЙН 25.1.7-Т ЗААСАН ЗААЛТ

Төрийн аудитын тухай хуулиар Үндсэн хуулийн 25.1.7-ны “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн хэсгийг нарийвчлан зохицуулсан байна.

Тус хуулийн 4-р зүйлд нэр томъёоны тайлбарын талаар зохицуулсан төрийн санхүү, төсвийн хяналтын талаар дор дурдсанаар заасан байна.

4.1.1. "төрийн санхүү, төсвийн хяналт" гэж төрийн санхүү, төсөв, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, эргэн төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах үйл ажиллагаа, хувьчлал, дуудлага худалдаа, техник, эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, зээллэг, гадаад зээл, тусламж, хандив, санхүүгийн дэмжлэг, өрийн баталгаа, үнэт цаас, бүх төрлийн гэрээ, хэлцэл болон бусад аливаа үйл ажиллагааны

төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалт, хэрэгжилт, тайлагнал болон нийтийн өмчтэй холбоотой бүх үйл ажиллагаанд төрийн аудит хийхийг;

4.1.3."төрийн аудитын байгууллага" гэж төрийн аудит хийх чиг үүрэг бүхий Үндэсний аудитын газар, аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар, төрийн аудитын байгууллагын албан хаагчийг;

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага байна. Дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- Шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;
- Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид "Улсын Их Хурал" гэх/-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх;
- Төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх;
- Нийтийн өмчтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актыг боловсронгуй болгох, батлан гаргах талаар эрх бүхий этгээдэд зөвлөмж өгөх.

Санхүүгийн аудит

- Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.
- Төрийн аудитын байгууллага төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдийн санхүүгийн тайланд аудит хийж болно.
- Төрийн аудитын байгууллага Улсын Их Хурлын зөвхөн санхүүгийн тайланд аудит хийнэ.
- Төрийн аудитын байгууллага энэ хуульд заасан санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.
- Аудитын хуулийн этгээд энэ хуулийн 8.4-т заасны дагуу санхүүгийн тайлангийн аудит хийхдээ төрийн аудитын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллана.
- Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит хийхэд гарсан шууд ба шууд бус зардлыг нөхөх зорилгоор шалгагдагч этгээдээс аудитын үйлчилгээний төлбөр авна. Аудитын үйлчилгээний төлбөрийн жишиг үнийг Монгол Улсын Ерөнхий аудиторовын саналыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтоож, холбогдох байгууллагуудын төсөвт тусгана.
- Энэ хуулийн 8.4-т заасан аудитын хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулах бөгөөд аудитын хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

Гүйцэтгэлийн аудит

- Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэхэд аудит хийнэ.
- Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн тогтолцоо, үйл ажиллагааны зохион байгуулалт, түүний хэмжилт, дотоод хяналт үр нөлөөтэй эсэхэд дүгнэлт өгч, тэдгээрийг сайжруулах чиглэлээр гүйцэтгэлийн аудит хийнэ.

Нийцлийн аудит

- Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээд үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актыг хэрэгжүүлж байгаа эсэхэд аудит хийнэ.
- Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын нийцэлд аудит хийнэ.
- Төрийн аудитын байгууллага нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудиттай хослуулан хийж болно.

Дээрхээс үзэхэд төрийн санхүү, төсвийн хяналтын талаар тодорхойлж, төрийн аудитын бүрэн эрх, түүний хэлбэрүүдийн талаар нарийвчлан зохицуулсан байна.

Хуулийн нэр	Батлагдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль	2020 оны 05 сарын 07-ны өдөр	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд оршино.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай

ҮНДСЭН ХУУЛИЙН 25-Р ЗҮЙЛИЙН 25.1.7-Т ЗААСАН ЗААЛТ

Тус хуульд улсын их хурлын бүрэн эрхийг дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

9.2.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг уялдуулан батлах;

9.2.2.Энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.12, 4.1.13-д заасан баримт бичгийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг тус тус баримтлан батлах;

9.2.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6-д заасан баримт бичигт нийцүүлэн батлах;

9.2.4.Энэ хуулийн 6.6-д заасны дагуу хүргүүлсэн Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг хэлэлцэн батлах;

9.2.5.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах, түүнчлэн холбогдох судалгаа, шинжилгээ, явцын болон эцсийн үнэлгээг үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Засгийн газарт чиглэл өгөх;

9.2.6.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жил бүрийн төсвийг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн батлах;

9.2.7.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл

ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хэлэлцэж, шаардлагатай бол Засгийн газарт чиглэл өгөх, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг Ерөнхий сайдад хүргүүлэх;

9.2.8.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн гүйцэтгэлийн үр дүнгээс хамаарч Засгийн газрын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, шаардлагатай бол Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлд заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг гаргах;

9.2.9.Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор энэ хуульд заасан зарчмыг баримтлаагүй, шаардлагыг хангаагүй хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэн батлахгүй байх.

Хуулийн нэр	Батлагдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	2020 оны 05 сарын 13-ны өдөр	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурал /цаашид "Улсын Их Хурал" гэх/-ын чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай

ҮНДСЭН ХУУЛИЙН 27 ДУГААР ЗҮЙЛИЙН 27.6,7

Монгол улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

44.2.Нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно.

14.1. Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар санал хураалтыг нууцаар явуулна.

14.2.Ил санал хураалтыг цахимаар, эсхүл гар өргөж, нууц санал хураалтыг цахимаар, эсхүл санал хураах хуудсаар явуулна

ҮНДСЭН ХУУЛИЙН 29 ДУГААР ЗҮЙЛИЙН 29.3

83 дугаар зүйл.Албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх

83.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан асуудлаар Цэц дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд ирүүлсэн бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ

84 дүгээр зүйл.Албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх

84.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц дүгнэлт гаргаж ирүүлсэн бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ

/Үндсэн хуулийн 66.2.4. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх./

Монгол Улсын их хурлын хуралдааны дэгийн тухай хуульд Улсын их хурлын гишүүнийг эгүүлэн татах хэлэлцүүлгийг явуулах журмыг тодорхойлж өгчээ.

2.2. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛЬ

Хуулийн нэр	Батлагдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Төсвийн тухай хууль	2011 оны 12 сарын 23-ны өдөр	Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>ҮНДСЭН ХУУЛИЙН 25-Р ЗҮЙЛИЙН 25.1.7-Т ЗААСАН ЗААЛТ</p> <p>Төрийн аудитын хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор тус хуулийн 8-р зүйлийн 8.5.1-г “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх” буюу гэж төрийн аудитын байгууллагад хүргүүлэх тухай нэмэлт өөрчлөлт оруулсан байна.</p>		
Хуулийн нэр	Нэмэлт өөрчлөлт оруулсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Зөрчлийн тухай хууль	2021 оны 12 сарын 24-ны өдөр	Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>ҮНДСЭН ХУУЛИЙН 28 ДУГААР ЗҮЙЛИЙН 28.2</p> <p>15.33 дугаар зүйл. Парламентыг үл хүндэтгэх</p> <p>1. Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны сонсголын дэг, журмыг зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>2. Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, эсхүл гэрч, шинжээч мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан эсхүл тусгай шалгалтад саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>3. Шинжээч Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дүгнэлт гаргаж өгөөгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>		

4.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос шаардсан нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй, гаргаж өгөөгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос шаардсан нотлох баримтыг устгасан, өөрчилсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Энэ зүйлийн 1-5 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан болон Улсын Их Хурлаас зохион байгуулах сонголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс таггалзсан, хуралдаан, сонголд оролцсон этгээд дэг зөрчсөн, санаатайгаар худал мэдээлэл өгсөн, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар албан тушаалтанд оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хүнийг нэг зуугаас гурван зуун нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянгаас дөрвөн мянган нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хуулийн нэр	Нэмэлт өөрчлөлт оруулсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Нийтийн сонсголын тухай хууль	2021.12.24	Энэ хуулийн зорилт нь төрийн байгууллага, албан тушаалтан энэ хуульд заасан асуудлаар нийтийн сонсголыг зохион байгуулж төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангахад оршино.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай

ҮНДСЭН ХУУЛИЙН 28 ДУГААР ЗҮЙЛИЙН 28.2

Тус нэмэлт өөрчлөлтийн 15 дугаар зүйлийн 15.1-д сонголд оролцогч нарын эрхийг дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

- 15.1.1.энэ хууль болон холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэх;
- 15.1.2.сонсголын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал, тайлбарыг хянах;
- 15.1.3.сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй, хүндэтгэлтэй хандахыг шаардах;
- 15.1.4.холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрх эдлэх.
- 15.2.Сонголд оролцогч дараах үүрэг хүлээнэ:
 - 15.2.1.сонсгол зохион байгуулагчийн дуудсанаар сонголд хүрэлцэн ирэх;
 - 15.2.2.сонсголын дэг сахих;
 - 15.2.3.сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
 - 15.2.4.сонголд үнэн зөв мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх;
 - 15.2.5.холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх.
- 15.3.Сонголд оролцогч нь сонсголын явцад бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох, яриаг нь таслах, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.
- 15.4.Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор сонсголыг дохионы хэлмэрчтэй явуулна.
- 15.5.Сонсгол зохион байгуулагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонголд оролцох, ажиглах боломжийг хангана."

Түүнчлэн, тус нэмэлт өөрчлөлтийн 17 дугаар зүйлд сонсгол даргалагчийн эрх үүргийг дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

<p>17.1.Сонсгол даргалагч сонсголыг хуульд заасны дагуу удирдан зохион байгуулах, сонсголын асуудлыг тал бүрээс нь үнэн бодитойгоор тогтоох, сонсголд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх, оролцогчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, сонсголын дэг сахиулах үүрэгтэй.</p> <p>17.2.Сонсгол даргалагчийг сонгох, томилох асуудлыг энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.</p> <p>17.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголын даргалагчийг Байнгын, дэд хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно. Сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална.</p> <p>17.4.Сонсгол даргалагч дараах нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ:</p> <p>17.4.1.сонсголын бэлтгэлийг хангах;</p> <p>17.4.2.сонсголыг товлосон цагт эхлүүлж, дэгийн дагуу явуулах;</p> <p>17.4.3.сонсголд оролцож байгаа этгээдэд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх;</p> <p>17.4.4.сонсголын тайланг хянаж, эрх бүхий этгээдэд танилцуулах;</p> <p>17.4.5.хүндэтгэн үзэх шалтгаантай оролцогчид чөлөө өгөх;</p> <p>17.4.6.сонсголын дэг сахиулах, оролцогчдоос дэг сахихыг шаардах;</p> <p>17.4.7.сонсголын дэг зөрчигчид холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах;</p> <p>17.4.8.сонсголын асуулт, хариулт, тайлбар, санал, мэдээлэл нь сонсголын сэдэвт хамааралгүй, ялгаварлан гадуурхсан, доромжилсон үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох;</p> <p>17.4.9.сонсголын дэг зөрчсөн, эсхүл энэ хуулийн 15.3-т заасан үйлдэл гаргасан оролцогчид сануулах, зайлшгүй шаардлагатай бол үг хэлэх эрхийг нь хасах;</p> <p>17.4.10.сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх;</p> <p>17.4.11.сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах."</p>		
Хуулийн нэр	Нэмэлт өөрчлөлт оруулсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	2021 оны 12 сарын 24-ны өдөр	Энэ хуулийн зорилт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>ҮНДСЭН ХУУЛИЙН 28 ДУГААР ЗҮЙЛИЙН 28.2</p> <p>Зөрчлийн шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.</p> <p>9.3.3 Зөрчлийн тухай хуулийн 15.33 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шүүгчийн торгох шийтгэлийн биелэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, энэ хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бусад зөрчил үйлдсэн хүнд оногдуулсан шүүгчийн торгох шийтгэлийн биелэлтийг тухайн зөрчилд хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулсан эрх бүхий байгууллага тус тус хариуцна."</p>		
Хуулийн нэр	Нэмэлт өөрчлөлт оруулсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга

Эрүүгийн хууль	2021 оны 12 сарын 24-ны өдөр	Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>ҮНДСЭН ХУУЛИЙН 28 ДУГААР ЗҮЙЛИЙН 28.2</p> <p>Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн талаар зохицуулсан байдаг. Энэхүү зүйлийн 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21.3 дахь зүйлийн 1 дэх хэсэг, 21.4 дэх зүйлийн 1 дэх хэсгийн шүүхэд гэсний дараа эсхүл Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд гэж тус бүр өөрчилсөн байна. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн уг заалтыг эрүүгийн хуулиар хамгаалж баталгаажуулсан байна.</p>		

2.3. АНХДАГЧ ХУУЛЬ

Хуулийн нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль	2021 оны 12 сарын 24-ны өдөр	Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагаанд тавих Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд Улсын их хурлын онцгой бүрэн эрхийг тодорхойлохдоо “25.1.8. хууль, Улсын их хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах” гэж заасан байдаг. Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.3.4-т “Хянан шалгах түр хороог хуулиар тусгайлан тогтоосон эрх хэмжээний хүрээнд мэргэжлийн хараат бус шинжээч томилох, гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах зэрэг арга хэрэгсэл ашиглан Засгийн газар, түүний байгууллага, албан тушаалтан хууль зөрчсөн эсэх, эрх мэдлээ урвуулан ашигласан эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан эсэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэх зорилгоор байгуулах, түр хорооноос гаргасан дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй байх зарчмыг хуульчлах;” гэсний хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсан. Уг хууль нь 7 бүлэг, 59 зүйлтэй. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиуд, тэдгээрийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөлөл, тухайн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарч байгаа хүндрэл бэрхшээл ямар түвшинд байгаа, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох болон тэдгээрийг хэрэгжүүлэхээр Засгийн газраас батлан гаргасан хэм хэмжээний актууд хуульд нийцэж байгаа эсэхэд нэгдсэн хяналт тавих тогтолцоог уг хуулиар зохицуулна.</p>		

2.4. УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Хуулийн нэр	Бичигдсэн хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Ерөнхийлөгчийн тухай хууль	2021 оны 04 сарын 26-ны өдөр	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх, халдашгүй байдал, баталгаа, үйл ажиллагаанд хориглох зүйл, бүрэн эрх дуусгавар болсны дараах хязгаарлалт, баталгааг тогтоох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай ҮНДСЭН ХУУЛИЙН 22-Р ЗҮЙЛИЙН 22.3-Т ЗААСАН ЗААЛТ</p> <p>Уг төслийн зохицуулалтыг авч үзвэл 10-р зүйлийн 10.6-т дээрх Үндсэн хуулийн заалтыг нарийвчлан зохицуулсан байна.</p> <p>Ерөнхийлөгч дараах тохиолдолд Улсын Их Хурлыг тараах зарлиг гаргах үүрэгтэй:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш 45 хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол; • Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас хойш 30 хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол; • Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш 30 хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол. 		

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН АКТ

3.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Тогтоолын нэр	Батлагдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	2020 оны 08 сарын 20-ны өдөр	Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай ҮНДСЭН ХУУЛИЙН 25-Р ЗҮЙЛИЙН 25.1.7-Т ЗААСАН ЗААЛТ</p> <p>Уг тогтоолд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан байна. Үүнд:</p> <p>1/Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт баталж, хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах;</p> <p>2/Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;</p>		

3/Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн үнэлгээ болон өрийн тогтвортой байдлын шинжилгээ хийх;

4/Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан экспортыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгон иргэдийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засагт нөлөө үзүүлэх 10 томоохон төслийг санхүүгийн боломжит бүх арга хэрэгслийг ашиглан санхүүжүүлэх.

ДӨРӨВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хууль тогтоох эрх мэдэлтэй холбоотойгоор 21 дүгээр зүйлийн 21.4 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.2, 3,4 дахь хэсгүүд, 25 дугаар зүйлийн 25.1.6, 7, 16 дахь хэсгүүд, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2, 6 дахь хэсгүүд, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг гэсэн заалтууд өөрчлөгдсөн. Эдгээрийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн баталсан болон шинэчлэгдэн найруулагдсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль, Улсын их хуралд өргөн баригдаагүй байгаа хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоол зэргийг судаллаа.

Энэхүү хэсэгт анхдагч хууль 1, шинэчлэн найруулсан хууль 5, нэмэлт өөрчлөлт оруулсан хууль 5, Улсын их хурлын тогтоол 1, Улсын их хуралд өргөн баригдаагүй байгаа хуулийн төсөл 1, нийт 13 эрх зүйн актыг сонгон авч дүн шинжилгээ хийж судалсан.

Ялангуяа Улсын Их Хурлын шинэчилсэн найруулга нь хууль тогтоох эрх мэдлийн харилцааг нарийвчлан зохицуулсан органик хууль байсан бөгөөд уг хуулийг илүү нарийвчлан дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн анхдагч хууль болох Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн агуулгын талаар судалсан болно.

IV. “ГҮЙЦЭТГЭХ ЭРХ МЭДЭЛ”-Д ХОЛБОГДОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭН ГАРАХ ХУУЛЬ ТОГТООМЖУУДАД ХИЙСЭН СУДАЛГАА

НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ

ХУУЛЬ		
Нэг	ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА	
№	Хуулийн нэр	Батлагдсан хугацаа
1	Монгол Улсын Их Хурлын тухай хууль	2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр
2	Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр
3	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай ¹⁵	2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр
Хоёр	НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ	
№	Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт оруулсан хугацаа
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр
2	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль	2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр
Гурав	УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	
№	Төслийн нэр	Бичигдсэн хугацаа
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр (ХЗДХЯ-ны цахим хаягт байршуулсан хугацаагаар)
2	Доорх хуулийн төслүүд нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор боловсруулсан хуулийн төслүүд болно.	
2.1	Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай	
2.2	Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	
2.3	Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	
2.4	Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	
2.5	Дотоодын цэргийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	
2.6	Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	
2.7	Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	

¹⁵ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, <https://old.legalinfo.mn/law/details/15826>

2.8	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2.9	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2.10	Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2.11	Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
2.12	Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
2.13	Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2.14	Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2.15	Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2.16	Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2.17	Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2.18	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2.19	Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2.20	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
2.21	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2.22	Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

ХОЁР. ХУУЛЬ

ҮНДСЭН ХУУЛИЙН ГУЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 7 ДАХЬ ХЭСЭГ

Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 31.7 дахь хэсгийг хүчингүй болгосноос хойш Монгол Улсын улс төрийн орчинд өмнөх Ерөнхийлөгч Х.Баттулгын бүрэн эрхтэй холбоотой олон асуудал өрнөсөн. Тухайлбал, тэрбээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө сонгогдсон тул өмнөх зохицуулалтын дагуу дахин сонгогдохоор нэр дэвших эртэй эсэх, хэрэв сонгогдвол 4 жилийн хугацаатай эсвэл 6 жилийн хугацаагаар сонгогдох эсэхтэй холбоотой асуултууд гарч ирсээр байсан. Зарим судлаачид үүнийг Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль хэрхэн батлагдахаас, Үндсэн хуулийн цэц хэрхэн тайлбарлахаас хамаарна¹⁶ гэж байсан бөгөөд тус хуулийг батлахдаа “... зөвхөн нэг удаа сонгоно.” буюу “өмнө нь Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байгаагүй байх” гэсэн шаардлагыг тодорхой хуульчлаагүй.

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөлд “Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2025 онд болох Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө.” хэмээн тусгасан байсан¹⁷. Өөрөөр хэлбэл, одоогийн Ерөнхийлөгчийн дахин сонгогдох бүрэн эрхийг хязгаарлахгүйгээр зохицуулсан байсан нь хэлэлцүүлгийн шатанд өөрчлөгдөн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох өдрөөс дагаж мөрдөхөөр хуульчилсан.

¹⁶ “Ерөнхийлөгч Х.Баттулга дахин нэр дэвших боломжтой юу?” 2020.02.07 - нийтлэл, www.news.mn [Сүүлд үзсэн: 2021.02.05]

¹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 02 дугаар дүгнэлт, <https://old.legalinfo.mn/law/details/16278>

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдөр шинэчлэн баталсантай холбогдуулан хэсэг иргэн Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан. Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд мэдээлэл гаргагч иргэд “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхой хуульчлаагүйн улмаас Үндсэн хууль биелэгдэхгүй зөрчигдөх нөхцөл бүрдэж, хэрэв өмнө Ерөнхийлөгчөөр сонгогдож байсан хүн дахин сонгогдсон тохиолдолд 10-14 жилийн хугацаанд ерөнхийлөгчийн бүрэн эрхийг эдэлж, улмаар нэг хүний засаглалын хэлбэр тогтох нөхцөлийг ч бүрдүүлж болохоор байна.” гэж тайлбарлаж байв. Түүнчлэн хэрэв тухайн үеийн Ерөнхийлөгч дахин сонгогдохоор бол өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан тушаалд 4 жилийн хугацаагаар 2 удаа сонгогдон ажиллаж байсан нэр бүхий иргэдээс давуу эрхтэй болж, Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчих нөхцөлийг бүрдүүлэхээр байгаа тухай ч байр сууриа илэрхийлж байсан юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц “Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтын агуулгыг уг хуульд бүрэн тусгаагүйн улмаас дээрх шаардлагыг хангасан иргэнийг нэр дэвшүүлэх хууль зүйн боломж бүрдэхгүй болох, улмаар эрх зүйн тодорхой бус, хийдэлтэй байдлыг үүсгэж, Үндсэн хуулиар баталгаажсан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмыг зөрчих үндэслэлийг бүрдүүлсэн байна.” гэсэн үндэслэлээр Үндсэн хуулийг зөрчсөн гэж дүгнэжээ. Үүний дагуу Улсын Их Хурал шинээр баталсан Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулсан байдаг^[3].

Энэхүү заалт батлагдсанаар өмнө нь Ерөнхийлөгчөөр ажиллаж байгаагүй иргэн нэр дэвших бөгөөд Монгол Улсад Ерөнхийлөгч зөвхөн нэг удаа зургаан жилийн хугацаагаар сонгогдон ажиллахаар болсон. Үүнээс хойш Монгол Улсад өмнө нь сонгогдон ажиллаж байсан аль ч Ерөнхийлөгч дахин нэр дэвших эрхгүй болсон юм.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 сарын 09-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 2.3-т “Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох насны доод хязгаарыг өндөрсгөж, зөвхөн нэг удаа сонгогдох; Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, бүрэн эрхийн хугацаатай холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх;” чиглэлийг баримтлахаар тусгасан байна.

- **Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль**

2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн батлагдаж, хүчин төгөлдөр үйлчилж байгаа тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт зааснаар мөн хуульд заасан шаардлагыг хангасан, Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаагүй Монгол Улсын уугуул иргэн зөвхөн нэг удаа Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй гэж 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 02 дугаар дүгнэлтээр Үндсэн хууль зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрч, 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулж, Ерөнхийлөгчөөр нэр дэвших эрх нээгдэх шалгуурыг Үндсэн хуулийн Гучдугаар зүйлд нийцүүлэн нарийвчлан тогтоож, хуульчилсан.

- **Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль**

1993 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдаж, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна.” гэсэн заалтад нэмэлт, өөрчлөлт оруулаагүй, мөн тус хуулийг шинэчлэн найруулж, батлаагүй байна.

ҮНДСЭН ХУУЛИЙН ГУЧИН ГУРАВДУГААР ЗҮЙЛИЙН 4 ДЭХ ХЭСЭГ

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14 -ний өдөр хэлэлцэн баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийг “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно.” гэж өөрчлөн найруулсан. Үүний хүрээнд УИХ-аас “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт,

өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2020 оны 02 дугаар тогтоолын дагуу “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг гаргасан. Уг тогтоолын хавсралтын 2.3-г “Ерөнхийлөгчид хуулиар олгосон бүрэн эрх Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлд заасан хүрээнд байх нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид оруулах, Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрх олгох асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх үүднээс Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэхийг” Засгийн газарт даалгасан байна.

Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалаар дараах хууль тогтоомжуудад заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Үндсэн хуульд нийцүүлэн өөрчлөх талаар тусгажээ¹⁸.

- Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай, Монгол хэлний тухай, Ирээдүйн өв сангийн тухай, Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиудад Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдоогүй буюу зөвлөл, хороонд төлөөлөл санал болгох, зарим зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, мөн Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарахгүй асуудлаар бүрэн эрх олгосон агуулга бүхий зохицуулалтууд байна.
- Төрийн албаны тухай хуульд Монгол Улсын Үндсэн хуульд Ерөнхийлөгчид олгоогүй бүрэн эрхийг хуульчилснаас үүдэлтэй Гаалийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Дипломат албаны тухай, Дотоодын цэргийн тухай, Монгол Улсын хилийн тухай, Цагдаагийн албаны тухай, Тагнуулын байгууллагын тухай, Төрийн аудитын тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай зэрэг салбар хуульд төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэв олгох, тангараг өргөх болон дүрэмт хувцасны загвар, түүний эдэлгээний хугацаа, хэрэглэх журам, энгэрийн тэмдгийн загвар батлах эрхийг олгожээ.
- Прокурорын тухай хуулийн хуулийн Улсын Ерөнхий Прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын Ерөнхийлөгч томилох бүрэн эрхийн тухайд Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа боловч прокурорын тангараг өргөх, зэрэг дэв тогтоох болон олгох журам, прокурорын мэргэжлийн болон ёс зүйн зөвлөлийн дүрэм, ажиллах журам, прокурорын сахилгын дүрэм, прокурорын байгууллагын бэлгэдэл, далбаа, дүрэмт хувцас, энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батлахаар зохицуулсан нь Үндсэн хуулиар олгогдоогүй эрхийг Ерөнхийлөгчид олгожээ.
- Мөн Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6.4-д заасан Ерөнхийлөгч Улсын Ерөнхий Прокурор, түүний орлогчийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох шийдвэр гаргахдаа “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан” гэсэн үндэслэлийг харгалзан үзэх нь прокурорын хараат бус байх зарчмыг гажуудуулахад хүрч болзошгүй, түүнчлэн энэ талаар олон улсын байгууллагуудын зөвлөмж ирүүлсээр байгаа тул холбогдох өөрчлөлтийг хийх шаардлагатай гэжээ.
- Дипломат албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан “Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, Онц бөгөөд бүрэн эрхт Элчин цолыг Монгол улсын Ерөнхийлөгч ... олгоно” гэсэн эрх нь Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгогдоогүй эрх тул Үндсэн хуульд нийцүүлэх шаардлагатай байна гэж тус тус үзжээ.

¹⁸ Хууль зүй, дотоод хэргийн яам “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал” 2021.04.26, [Торис: Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай /Шинэчилсэн найруулга/ | Хууль зүй, дотоод хэргийн яам](#) [Сүүлд үзсэн: 2022.02.21]

Энэхүү шинэчилсэн найруулгын төслөөс үзвэл эрх мэдэл хуваарилах зарчмын хувьд Үндсэн хуульд заасан эрх мэдлийн хяналт, тэнцлийг хангах, Ерөнхийлөгчөөс бусад эрх мэдэл рүү халдах, өөртөө эрх мэдэл төвлөрүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна.

Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Үндсэн хуульд нийцүүлэх ажлын хүрээнд Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаагүй харин 1993 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ерөнхийлөгчийн тухай хуульд 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна¹⁹.

ҮНДСЭН ХУУЛИЙН ГУЧИН ГУРАВДУГААР ЗҮЙЛИЙН 1.2 ДАХЬ ЗААЛТ БОЛОН ГУЧИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 2 ДАХЬ ХЭСЭГ

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцэн баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр гучин гуравдугаар зүйлийн нэг дэх хэсгийн 2 дахь заалтыг хүчингүй болгож, Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг “39.2. Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн олонхыг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг; бусад тохиолдолд Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхыг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна.” гэж өөрчлөн найруулсан. Үндсэн хуулийн энэ өөрчлөлтийн хүрээнд УИХ-аас “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2020 оны 02 дугаар тогтоолын дагуу “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсан. УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтын хоёр дахь хэсэгт гүйцэтгэх эрх мэдэлтэй холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан баримтлах чиглэлийн талаар тус тогтоолын 2.1-д “сонгуулийн дүнгээр аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй тохиолдолд улс төрийн нам, эвсэл заавал олонхыг бүрдүүлж Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх шаардлагыг хуульчлах;” хэмээн тусгасан байна.

Үүний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан байна.

Дээрх хуулиуд нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу батлагдсан бөгөөд 2020 оны УИХ-ын сонгуулиар Монгол Ардын нам УИХ дахь олонхын суудлыг авч Ерөнхий сайдаа томилсон. Гэхдээ 2020 оны 7-р сарын 1-нд Ерөнхийлөгчийн тамгын газрын албан ёсны вэбсайтад “...Ерөнхий сайдад намын дарга У.Хүрэлсүхийг нэр дэвшүүлсэн талаар танилцуулж, зөвшилцөх саналаа өргөн барилаа. ...Ерөнхийлөгч Х.Баттулга Ерөнхий сайдад нэр дэвшигчийг зөвшилцөх саналыг хүлээн авч, УИХ-д оруулахаа мэдэгдэв”²⁰ гэсэн мэдээ гарсан байдаг бөгөөд судлаачдын зүгээс дээрх мэдэгдэл нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжтэй гэсэн байр суурь гарч байсан байна.

ҮНДСЭН ХУУЛИЙН ГУЧИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 1 БОЛОН 3 ДАХЬ ХЭСЭГ

УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтын Хоёрдугаар хэсэгт гүйцэтгэх эрх мэдэлтэй холбоотой буюу Засгийн газрын эмхлэн байгуулах нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан баримтлах чиглэлийн талаар тус тогтоолын 2.1.2-д “Ерөнхий сайд Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, зөвшилцөж чадаагүй тохиолдолд өөрөө өргөн мэдүүлэх зохицуулалтыг хуульчлах”, 2.1.3-д “Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийн дөрвөөс илүүгүй нь Улсын Их Хурлын гишүүн байж болох зохицуулалтыг холбогдох хуульд тусгах;” хэмээн тусгасан байна.

Улс төрийн хүрээнд:

¹⁹ Төрийн мэдээлэл, 2020.06.23, №23 /1126/, 1222 дахь тал

²⁰ “Монгол Улсын Ерөнхий сайдыг нэр дэвшүүлэхээр зөвшилцөх саналыг өргөн барьлаа,” мэдээ, 2020.07.01, <https://president.mn/14757/> [Сүүлд үзсэн: 2022.02.22]

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнтэй хамт Гучин есдүгээр зүйлийн 39.1 болон Гучин есдүгээр зүйлийн 39.3 дахь заалтууд мөн үйлчилж эхэлсэн билээ. Тухайн үед буюу 2020 оны 5 сард эрх барьж байсан Засгийн газрын гишүүд бүгд Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг давхар хашиж байсан. Иймд, Улсын Их Хурлаас 5 хүртэлх гишүүн Засгийн газрыг гишүүний албан тушаалыг хавсран хэрэгжүүлэх тухай Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тухайн үеэс эхлэн мөрдөх ёстой байсан ч тус Засгийн газар огцролгүй бүрэн эрхээ хэрэгжүүлсээр байсан.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу шинэ засгийн газар 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр эмхлэн байгуулагдсан. Гэвч тус Засгийн газар 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр огцорсноор удаах Засгийн газар 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр байгуулагдав. Эдгээр Засгийн газруудын хувьд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн холбогдох заалтын дагуу Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч байгуулагдсан.

Тодруулбал, өдгөө эрх барьж буй Засгийн газарт:

- Ерөнхий сайд, УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ
- Шадар сайд УИХ-ын гишүүн С.Амарсайхан
- Сангийн сайд УИХ-ын гишүүн Б.Жавхлан
- Боловсрол, шинжлэх ухааны сайд УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан
- Хууль зүй, дотоод хэргийн сайд УИХ-ын гишүүн Х.Нямбаатар нар ЗГ-ын гишүүн болон УИХ-ын гишүүний албан тушаалыг хавсарч байна.

Хууль зүйн хүрээнд:

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбоотойгоор 1993 оны 5 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан Монгол Улсын засгийн газрын тухай хуулийн зарим зохицуулалтад 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал:

Засгийн газрын бүрэлдэхүүн гэсэн 20 дугаар зүйлийн 20.1-д “Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлд заасан ёсоор Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно”.

Ерөнхий сайдын бүрэн эрх гэсэн 23 дугаар зүйлийн 23.1-д Ерөнхий сайд Үндсэн хуулийн дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцаж, дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон тэдгээрт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд Ерөнхийлөгчтэй зөвшилцөж чадаагүй тохиолдолд Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ;

Засгийн газрын гишүүний бүрэн эрх гэсэн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт Засгийн газрын гишүүн энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар олгосон бүрэн эрхтэй. Түүний дотор: 1/эрхэлсэн асуудлын хүрээнд төрийн бодлого боловсруулж, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх ажлыг Засгийн газрын өмнөөс эрхлэн гүйцэтгэж, зохих хүрээ, салбарын хөгжил, ажил хэргийн байдал, үр дүнг Ерөнхий сайдын өмнө дангаар, харин Засгийн газрын үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага тус тус хүлээнэ гэсэн өөрчлөлтүүд тус тус батлагджээ.

ҮНДСЭН ХУУЛИЙН ДӨЧИН ГУРАВДУГААР ЗҮЙЛИЙН 1 БОЛОН 2 ДАХЬ ХЭСЭГ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 1 сарын 9-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсан бөгөөд Үндсэн хуулийн 43 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан уг хуваарийн 2.2 дахь хэсэгт Засгийн газар танхимын зарчмаар, тогтвортой ажиллахтай холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална гэсэн байна. Үүнд:

1. Ерөнхий сайд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсны үндсэн дээр Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах зохицуулалтыг хуульчлах;
2. Ерөнхий сайдыг огцруулах, Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцрох талаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгах;
3. Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх асуудлаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгах.

Д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
-----	-------------	---------	---

Үүний дагуу өөрчлөгдсөн зохицуулалтыг тодруулбал,

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь одоогоор батлагдаагүй байгаа учир одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 1993 оны Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хэд хэдэн өөрчлөлт орсон байна.

2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар ЗГТХ-ийн 22.4-т заасан “*Улсын Их Хуралд олонхын суудал авч Засгийн газар байгуулсан эвсэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25.9-25.11-д заасны дагуу тарсан бол Ерөнхий сайд огцрох тухай хүсэлтээ 7 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна*”, 27.7-т заасан “*Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаа дуусахаас өмнө огцрох, өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсэх тухай саналыг Ерөнхийлөгч зөвшөөрөөгүй явдал нь Улсын Их Хурал уг асуудлыг хэлэлцэхэд саад болохгүй*”, 27.6-т “*Засгийн газар нь энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу бүрэн эрхийнхээ хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, 26 дугаар зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг Улсын Их Хурлаас хүсэх тухайгаа Ерөнхийлөгчид урьдчилан мэдэгдэж зөвшилцөн*” гэх хэсгүүдийг хүчингүйд тооцсон байна.

Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, түүнд нийцүүлсэн Засгийн газрын тухай хууль (ЗГТХ)-д оруулсан нэмэлт өөрчлөлт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга зэрэгт үндсэндээ Засгийн газрын тогтвортой байдлыг хангах зорилгоор итгэлийн санал хураалтын зохицуулалтад хэд хэдэн хязгаарлалт, шаардлагыг нэмжээ.

Төслийн шатанд Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг баталсан бол Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэх асуудлыг 6 сарын дотор дахин санаачлахгүй²¹. Мөн УИХ өөрт нь итгэл хүлээлгэж байгааг нотолсон болон огцрох тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол уг асуудлаарх 6 сарын дотор Засгийн газар өөрөө санаачлан авч хэлэлцэхгүй²² буюу УИХ-аас Засгийн газрыг огцруулах

²¹ Монгол улсын Засгийн газрын тухай хууль (1993) 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, <https://legalinfo.mn/mn/detail/344>

²² Монгол улсын Засгийн газрын тухай хууль (1993) 26 дугаар зүйлийн 4 дэх хэсэг

санал гаргахад хугацааны хязгаарлалт тогтоогоогүй зөвхөн Ерөнхий сайдад Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тогтоолын төсөл УИХ-д оруулахад хугацааны хязгаарлалт тогтоосон байна.

Парламентын хэлэлцүүлгийн шатанд конструктив механизмыг Үндсэн хуульд тусгах талаар нэлээдгүй хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнөсөн бөгөөд ямар нэгэн өөрчлөлтгүйгээр парламентын нийт гишүүдийн нэгээс доошгүй буюу 19 ба түүнээс дээш саналаар Засгийн газрыг огцруулах эсэх талаар хэлэлцэх боломжтой хэвээр үлдээсэн.

Процедурын шатанд 2019 оны Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газарт итгэл хүлээлгэхтэй холбоотой зохицуулалтад гол 2 өөрчлөлт орсон. УИХ-ын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй буюу 19-өөс доошгүй гишүүд Ерөнхий сайдыг огцруулах санал гаргах боломжтой хэвээр²³ бөгөөд харин албан ёсны санал гарснаар эсхүл Ерөнхий сайд тогтоолын төсөл оруулснаар өмнө 15 хоногийн дотор шийдвэрлэдэг байсан бол УИХ 3 хоногийн дараа хэлэлцэн эхэлж 10 хоногийн дотор шийдвэрлэхэд хугацааны хувьд илүү богиносгосон байна. Энэ нь шийдвэр хурдан гаргах, гүйцэтгэх эрх мэдлийг тодорхойгүй байдалд удаан байлгахаас сэргийлж байна.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн зохицуулалттай холбогдон ЗГТХ-ийн шинэчилсэн найруулга болон 2020 оны МУИХТХ нь уялдаа холбоотойгоор Үндсэн хуульд тусгагдсан үзэл баримтлалтай нийцэж байгаа бөгөөд ЗГТХ-ийн шинэчилсэн найруулга одоогоор хараахан батлагдаагүй байна.

ҮНДСЭН ХУУЛИЙН ДӨЧИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 1 БОЛОН 2 ДАХЬ ХЭСЭГ

2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараагаар хамгийн тогтвортой ажиллах боломжтой байсан У.Хүрэлсүхийн Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон. Ерөнхий сайд У.Хүрэлсүх Засгийн газрын тэргүүний ажлаасаа өөрийн саналаар огцрох хүсэлтээ өгсөн. Уг асуудлыг хуулийн хүрээнд авч үзвэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхий сайд У.Хүрэлсүх Засгийн газрын гишүүдээ өөрөө томилох, чөлөөлөх эрхтэй бөгөөд Шадар сайд Я.Содбаатар, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарын хүсэлтийг шийдвэрлээд өнгөрвөл энэ нь Ерөнхий сайдын бүрэн эрхийн хүрээнд шийдэгдэх байсан. Харин өөрөө огцрох асуудлыг гаргаснаар Ерөнхий сайдад хоёр сонголт үүссэн.

Нэгдүгээрт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээ зөв, буруу эсэхийг шийдүүлэх, өөрт нь **итгэл хүлээлгэх** асуудлыг тавих эрх нь Ерөнхий сайдад байсан ба уг агуулгын хүрээнд шийдвэл Монгол Улсын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2 дахь хэсэгт тусгагдсан байдлаар шийдвэрлэх байсан. Харин итгэл хүлээлгэх бус Ерөнхий сайд У.Хүрэлсүх ёс зүйн хариуцлага үүрч, огцрох хүсэлтээ гаргаснаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт *“Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос албан тушаалаас чөлөөлж өгөх тухай хүсэлтээ Ерөнхий сайд Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн нь Ерөнхий сайдад тус тус өргөн мэдүүлж болно”* хэмээн заасны дагуу УИХ-ын чуулганы хуралдаанаар тус асуудлыг хэлэлцэж, чуулганы хуралдаанд оролцсон 63 гишүүний 60 нь буюу 95.2 хувь нь дэмжсэнээр 31 дэх Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон. Үүнээс 6 хоногийн дараа 2021 оны 1 дүгээр сарын 27-ний өдөр Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ УИХ-ын чуулганаар томилогдож, 1 дүгээр сарын 29-ний өдөр танхимын сайд нарыг УИХ-д танилцуулснаар тангараг өргөж үүрэгт ажилдаа орсон. Ийнхүү дараагийн Ерөнхий сайдыг богино хугацаанд томилсон байдал нь цар тахлын үед засгийн газрын үйл ажиллагааг тасалдуулалгүй, төрийн ажлыг тогтвортой байлгах боломжийг бүрдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 2.2-т УИХ-н хаврын ээлжит

²³ Монгол Улсын Үндсэн хууль (1992) 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

чуулганаар “Засгийн газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж “*Ерөнхий сайд өөрт нь итгэл үзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хуралд оруулах зохицуулалтыг хуульчлах;*” гэж тусгажээ.

2.1. ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

Хуулийн нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Монгол Улсын Их Хурлын тухай хууль	2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр	Улсын Их Хурлын гишүүнээс Ерөнхий сайдыг огцруулах санал гаргах, шинэ Ерөнхий сайдыг томилоогүйгээс УИХ-г тараах Ерөнхийлөгчийн бүрэн эрх
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>8.1.11. Ерөнхий сайдыг огцруулах саналыг Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын бусад гишүүнтэй хамтарч гаргах;</p> <p>36.3.2. Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас хойш 30 хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч дараах тохиолдолд Улсын Их Хурлыг тараах шийдвэр;</p>		
Хуулийн нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	2020 оны 12 дугаар сарын 24-ны өдөр	Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох насны доод хязгаарыг өндөрсгөж, зөвхөн нэг удаа сонгогдох; Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, бүрэн эрхийн хугацаатай холбоотой зохицуулалт
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>5.4. Энэ хуулийн 3.1.2-т заасан шаардлага хангасан, Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаагүй Монгол Улсын уугуул иргэн зөвхөн нэг удаа Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй. /2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</p> <p>3.1.2. “нэр дэвшигч” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэг, энэ хуульд заасан шаардлагыг хангаж Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшин бүртгүүлж, нэр дэвшигчийн үнэмлэх авсан Монгол Улсын иргэнийг; /2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</p>		
Хуулийн нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр	Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх, томилох санал оруулах, Ерөнхий сайдыг томилох тогтоолыг батлах, томилоогүй бол дахин нэр дэвшүүлсэн хүнийг УИХ-д санал оруулах тухай; Ерөнхий сайдаас оруулсан итгэл хүлээлгэх тухай тогтоолын төслийг УИХ-аар хэлэлцэх;
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>28.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд оруулснаас хойш</p>		

Төрийн байгуулалтын байнгын хороо ажлын 3 өдрийн дотор хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

28.2. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

28.3. Нэгдсэн хуралдаан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, Ерөнхий сайдыг томилох асуудлаар ил санал хураалт явуулна. Нэр дэвшигчийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Ерөнхий сайдыг томилох тухай тогтоол баталсанд тооцно.

28.4. Нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дахин нэр дэвшүүлсэн хүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулж, энэ хуулийн 28.1, 28.2, 28.3-т заасан журмаар шийдвэрлэнэ.

100.1. Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

100.2. Холбогдох Байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна.

100.3. Энэ хуулийн 100.1-д заасан тогтоолын төслийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолын төслийг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, энэ тухай тогтоол баталсанд тооцно.

100.7. Ерөнхий сайдад итгэл үзүүлэх тогтоолыг баталсантай холбогдуулан шаардлагатай бол уг тогтоолд нийцүүлэн зохих хууль, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурал энэ хуульд заасан журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэхийг хүсэж, тогтоолын төсөл оруулсан тохиолдолд УИХ 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн, 10 хоногийн дотор итгэл хүлээлгэх эсэхээ шийдвэрлэхээр зохицуулсан байхад 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан МУИХЧХДХ-ийн шинэчилсэн найруулгаар Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ гэсэн зохицуулалтыг оруулсан байгаа нь Үндсэн хуульд процессын асуудлыг тодорхой заасаар байхад тус хугацааг уртасгасан буюу Үндсэн хуульд нийцээгүй зохицуулалт болсон байна.²⁴

2.2. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛЬ

Хуулийн нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр	Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр 7 дахь хэсэгтэй холбоотой зохицуулалт ороогүй. Ерөнхий сайдаар томилохоор нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхийлөгч 5 хоногийн дотор УИХ-д оруулна.

²⁴ Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан, Б.Мягмарсүрэн, “Монгол Улсын Үндсэн хууль дахь Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх зохицуулалт ба хууль тогтоох байгууллагын оролцоог хязгаарлах механизмын зарим асуудал” эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, УБ, 2021, 6 дахь тал, <https://legaldata.mn/b/867> [Сүүлд үзсэн: 2021.02.05]

<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p>		
<p>Хуулийн нэр</p>	<p>Батлагдах хугацаа</p>	<p>Нэмэлт, өөрчлөлтийн зохицуулах харилцааны товч утга</p>
<p>Монгол Улсын Засгийн газрын тухай хууль</p>	<p>2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр</p>	<p>Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийн дөрвөөс илүүгүй нь Улсын Их Хурлын гишүүн байж болох зохицуулалт нэмсэн.</p> <p>Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах тухай;</p> <p>Ерөнхий сайд, засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацааны тухай, Засгийн газрын тогтвортой ажиллах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох тухай;</p> <p>Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах, Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай;</p>
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэж тусгагдсан. Уг үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн 2020 оны 5 дугаар сарын 13-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “<i>Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлд заасан ёсоор Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална.</i>” Гэсний дараа “<i>Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.</i>” гэх өгүүлбэрийг нэмсэн.</p>		
<p>23.1.1. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд Ерөнхийлөгчтэй зөвшилцөж чадаагүй тохиолдолд Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.</p> <p>23.1.2. Засгийн газрын гишүүнийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тус тус заасны дагуу Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсны үндсэн дээр томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулахдаа захирамж гаргана;</p> <p>2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийг “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.” гэж өөрчилсөнд нийцүүлэн 2020 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23.1 дэх хэсэгт “Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон тэдгээрт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд Ерөнхийлөгчтэй зөвшилцөж чадаагүй тохиолдолд Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.” өөрчлөлт оруулж, мөн 23.2 дахь хэсгийг нэмсэн байна.</p>		

<p>Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр Дөчин гуравдугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт оруулсан өөрчлөлтийн дагуу 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийг өөрчлөн найруулсан.</p> <ol style="list-style-type: none"> 1. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь Үндсэн хуулийн Дөчдүгээр зүйлд заасан Засгийн газрын бүрэн эрхийн хугацаатай адил байх бөгөөд Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно. 2. Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоолыг баталсан тохиолдолд Ерөнхий сайд огцорно. 3. Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно. 4. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас чөлөөлөгдсөн, огцорсон, түүнчлэн нас нөгчсөн тохиолдолд түүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно. Ерөнхий сайд чөлөөлөгдсөн, огцорсон, нас нөгчсөн тохиолдолд Улсын Их Хурал 30 хоногийн дотор түүнийг нөхөн томило. 5. Засгийн газрын гишүүний орон гарсан тохиолдолд Ерөнхий сайд түүнийг энэ хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасан журмын дагуу 14 хоногийн дотор нөхөн томило. Нөхөн томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа тухайн Засгийн газрын бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна. 6. Ерөнхий сайдын бүрэн эрх биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсны улмаас чөлөөлөгдсөн, нас нөгчсөн үндэслэлээр хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд Ерөнхий сайдыг шинээр томилох хүртэл түүний үүргийг Шадар сайд гүйцэтгэнэ. 7. Засгийн газрын орон гарсан гишүүнийг нөхөн томилох хүртэл Ерөнхий сайд Засгийн газрын нэг гишүүнд түүний үүргийг хуваарилан хариуцуулж болно. 8. Бүрэлдэхүүнээрээ огцорсон Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүнийг дахин томилж болно. <p>Эдгээр зохицуулалтаар Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцсэн буюу нарийвчлан зохицуулсан байна</p>
<p>2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсэгтэй холбогдуулан 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.3 дахь хэсгүүдийг өөрчлөн найруулсан.</p> <ol style="list-style-type: none"> 26.1. Засгийн газар Улсын Их Хурлын итгэлийг хүлээсэн байвал зохино. 26.2. Ерөнхий сайд Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тогтоолын төслийг өргөн мэдүүлэхдээ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, төсөв тэдгээрийн зүйл, хэсэг, заалтын талаарх өөрийн байр суурь болон Улсын Их Хурлаас дэмжлэг хүсэж байгаа асуудлыг тодорхой илэрхийлсэн байна. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайд огцорно. 26.3. Улсын Их Хурал Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолыг баталсан бол энэ хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлыг дэмжсэнд тооцно. Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэх асуудлыг 6 сарын дотор дахин санаачлахгүй. <p>Энэхүү зохицуулалт нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсгийг нарийвчлан зохицуулсан байна.</p>

2.3. УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Хуулийн төслийн нэр	Төслийн бичигдсэн хугацаа	Төслийн зохицуулах харилцааны товч утга
Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн найруулга Улсын тухай шинэчилсэн	Тодорхойгүй	Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хуульчлах тухай

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх, баталгаа, халдашгүй байдал, үйл ажиллагаанд нь хориглох зүйл, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг дуусгавар болсны дараах хязгаарлалтыг тогтоох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зохицуулсан нийт 69 хуулиас 23 хуульд Монгол Улсын Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгоогүй бүрэн эрхийг олгосныг өөрчлөн, Засгийн газарт олгогдсон бүрэн эрхтэй давхардуулахгүйгээр уялдуулах гэсэн үзэл баримтлалтайгаар батлагдахаар төслийг боловсруулж байна.

ГУРАВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсэг, Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Гучин гуравдугаар зүйлийн 1.2 дахь заалт, Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дөчин гуравдугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэг, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж холбогдох дараах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн баталсан байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахаар төлөвлөгөөнд тусгасан боловч энэхүү судалгааг хийж буй өдрийн байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталж, Ерөнхийлөгчийн тухай хуульд 2020 оны 5 дугаар сарын 13-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр шинэчлэн баталж, Засгийн газрын тухай хуульд мөн өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Харин Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд бусад хуулиар бүрэн эрх олгохтой холбоотойгоор тус зүйлд заагдаагүй, хамаарахгүй бусад бүрэн эрхийг хүчингүй болгох буюу өөрчилж, үүнтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг хийхээр төсөлд тусгагдсан байна. Мөн энэхүү хуулийг шинэчлэн батлахтай холбоотойгоор бусад 20 орчим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулсан боловч Улсын Их Хуралд өргөн бариагүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох насны доод хязгаарыг өндөрсгөж, зөвхөн нэг удаа сонгогдох тухай болон Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, бүрэн эрхийн хугацаатай холбоотой зохицуулалтыг тусгажээ. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон Ерөнхийлөгчийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Ерөнхий сайдаар нэр дэвшүүлсэн хүнийг УИХ-д санал болгохтой холбоотой зохицуулалтад өөрчлөлт оруулсан байна.

V. ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАЖ, ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ

ХУУЛЬ		
Нэг	ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА	
№	Хуулийн нэр	Батлагдсан хугацаа
1	Монгол Улсын Шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ ²⁵	2021 оны 01 сарын 15-ны өдөр
Хоёр	НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ	
№	Хуулийн нэр	Батлагдсан хугацаа
1	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /нэмэлт, өөрчлөлт/	2021 оны 01 сарын 15-ны өдөр
Гурав	УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	
№	Хуулийн нэр	Бичигдсэн хугацаа
1	Шүүх байгуулах тухай хууль	тодорхойгүй
ЭРХ ЗҮЙН АКТ		
Нэг	УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ	
№	Тогтоолын нэр	Батлагдсан хугацаа
1	Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнээр томилох тухай ²⁶	2021 оны 11 сарын 18-ны өдөр
2	Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай ²⁷	2021 оны 11 сарын 25-ны өдөр
3	Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох тухай ²⁸	2021 оны 12 сарын 02-ны өдөр

²⁵ Монгол Улсын Шүүхийн тухай, <https://old.legalinfo.mn/law/details/16047>

²⁶ Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнээр томилох тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381511093001>

²⁷ Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай, <https://old.legalinfo.mn/law/details/17041?lawid=17041>

²⁸ Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389648521281>

ХОЁР. ХУУЛЬ

Доорх хүснэгтэд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 сарын 09-ний өдрийн 02 дугаарын хавсралтад заасан хуулиудад нэмэлт, өөрчлөлт хийгдсэн байдлыг авч үзэв.

№	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга	Нэмэлт, өөрчлөлт орсон эсэх
1	Шүүхийн захиргааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 он	<ul style="list-style-type: none"> Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүнд тавих болзол, шалгуур, тэдгээрийг сонгох, томилох, Зөвлөлийн даргыг сонгох журам; Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиг үүргийг тодорхойлох; Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулах журам. 	2019 оны 11 сарын 22-оос хойш шинэчилсэн найруулга батлагдаагүй байна
2	Шүүхийн сахилгын хорооны тухай хууль /Анхдагч хууль/	2020 он	<ul style="list-style-type: none"> Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүн, гишүүнд тавих болзол, шалгуур, бүрдүүлж байгуулах журмыг тогтоох; Шүүгчид хариуцлага хүлээлгэх журмыг хариуцлага зайлшгүй байх, зөрчлийн шинж байдалдаа тохирсон байх, давхардахгүй байх зарчмыг үндэслэн тодорхойлох; Хорооны бүрэн эрх, үйл ажиллагааны болон сахилгын зөрчил хянан шийдвэрлэх журмыг хуульчлах; Хорооны шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг гомдлын дагуу Улсын дээд шүүх эцэслэн хянах журмыг тогтоох. 	2019 оны 11 сарын 22-оос хойш батлагдаагүй байна
3	Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> Хүн ам, газар нутаг, шүүгчийн ажлын ачааллыг харгалзан тойргийн шүүх байгуулж болох үндэслэл, журмыг нарийвчлан тогтоох; Шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, тойргийн зарчмаар шүүх байгуулах нь шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр чөлөөлөх, шилжүүлэх үндэслэл болохгүй байх зохицуулалтыг хуульчлах. 	2019 оны 11 сарын 22-оос хойш нэмэлт өөрчлөлт батлагдаагүй байна

2.1. ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

Хуулийн нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
-------------	-------------------	---------------------------------

Монгол Улсын Шүүхийн тухай	2021 оны 1-р сарын 15	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шүүгчид тавих болзол, шаардлага, шүүгчийн бүрэн эрх, эрх зүйн байдал, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
----------------------------	-----------------------	---

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай

Тус хууль нь 16 бүлэг 118 зүйлтэйгээр хуульчлагдсан ба Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн агуулга болох “Шүүхийн ерөнхий зөвлөл”, “Шүүхийн сахилгын хороо” “шүүхийг тойргийн зарчмаар байгуулах” зохицуулалтыг хэрхэн дэлгэрүүлэн хуульчилсан тухай авч үзье.

- **Шүүхийн сахилгын хороо:** Шүүхийн тухай хуулийн XV бүлгийн 95-100 дахь зүйлүүдэд “Сахилгын хороо”, “Сахилгын хорооны зөвлөгөөн”, “Сахилгын хорооны дарга, гишүүний бүрэн эрх”, “Сахилгын хорооны дарга гишүүний үүрэг, хориглох зүйл”, “Сахилгын хорооны гишүүнийг чөлөөлөх, огцруулах, сахилгын бусад шийтгэл оногдуулах”, “Сахилгын хорооны ажлын алба” зэрэг харилцааг дэлгэрэнгүй зохицуулжээ. Эдгээр зохицуулалт төдийгүй, тус хуулийн бусад зохицуулалт нь бүхэлдээ Үндсэн хуулийн үзэл баримтлал болох “шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүн, гишүүнд тавих болзол, шалгуур, бүрдүүлж байгуулах журмыг тогтоож, шүүгчид хариуцлага хүлээлгэх журмыг хариуцлага зайлшгүй байх, зөрчлийн шинж байдалдаа тохирсон байх, давхардахгүй байх зарчмыг үндэслэн, хорооны бүрэн эрх, үйл ажиллагааны болон сахилгын зөрчил хянан шийдвэрлэх журмыг хуульчлах” Үндсэн хуулийн үзэл баримтлалыг дэлгэрүүлэн хуульчилжээ.
- **Шүүхийн ерөнхий зөвлөл:** Шүүхийн тухай хуулийн XIV бүлгийн 68-94 дүгээр зүйлүүдэд “Шүүхийн захиргаа”, “Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд баримтлах зарчим”, “Ерөнхий зөвлөл, түүний чиг үүрэг”, “Шүүхийн бие даасан байдлыг хангах”, “Шүүхийг хүний нөөцөөр хангах”, “Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах”, “Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах”, “Мэдээллээр хангах”, “Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа”, “Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох, томилох журам”, “Ерөнхий зөвлөлийн ажлын алба”, “Ерөнхий зөвлөлийн хуралдаан, түүнээс гарах шийдвэр”, “Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрх”, “Ерөнхий зөвлөлийн даргын бүрэн эрх”, “Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний хориглох зүйл”, “Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, огцруулах”, “Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх”, “Шүүхийн тамгын газар”, “Шүүхийн Тамгын газрын чиг үүрэг”, “Шүүхийн Тамгын газрын даргын бүрэн эрх”, “Шүүхийн захиргааны ажилтан”, “Шүүгчийн туслах”, “Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга”, “Шүүхийн захиргааны бусад ажилтан”, “Шүүхийн захиргааны ажилтны ёс зүй”, “Шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн зөрчилд гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх”, “Шүүхийн захиргааны ажилтны сургалт” зэрэг харилцааг дэлгэрэнгүй зохицуулжээ. Эдгээр зохицуулалт төдийгүй, тус хуулийн бусад зохицуулалт нь бүхэлдээ Үндсэн хуулийн үзэл баримтлал болох “Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүнд тавих болзол, шалгуур, тэдгээрийг сонгох, томилох, Зөвлөлийн даргыг сонгох журам” ба “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиг үүргийг тодорхойлох” Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тусгажээ.

Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах: Шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах” харилцааг зохицуулахдаа “Шүүхийг Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасан журмын дагуу зөвхөн хуулиар байгуулж, өөрчлөн байгуулж, татан буулгана” гэсэн ингэхдээ “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэсэн журмыг тогтоож өгчээ. Тийм боловч энэхүү хуулиар “шүүхийг тойргийн зарчмаар байгуулахтай холбоотой” Үндсэн хуулийн үзэл баримтлал болох “хүн ам, газар нутаг, шүүгчийн ажлын ачааллыг харгалзан тойргийн шүүх байгуулж болох үндэслэл, журмыг нарийвчлан тогтоох”, “шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, тойргийн зарчмаар шүүх байгуулах нь шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр чөлөөлөх, шилжүүлэх үндэслэл болохгүй байх зохицуулалтыг хуульчлах” асуудал зохицуулагдаагүй байгааг анхаарууштай байна.

2.2. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛЬ

Хуулийн нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл	2021 оны 1-р сарын 15-ны өдөр	Хуульчийн эрх зүйн байдал, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, мэргэжлийн нэр хүнд, хариуцлагын тогтолцоо, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>Тус хуульд дараах агуулга батлагджээ. Үүнд:</p> <p>51.2.Хяналтын зөвлөл нь хуульчдаас бүрдсэн таван гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийг гурван жилийн хугацаагаар томилно.</p> <p>52.1.Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо /цаашид "Шалгалтын хороо" гэх/ нь Хуульчдын холбооны гишүүн, хуульч профессоруудын төлөөлөл оролцсон 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.</p> <p>54.3.Ёс зүйн хорооны гишүүн нь Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнээр нэр дэвшиж байгаа прокурор, өмгөөлөгчийн зан байдлын талаар дүгнэлт гаргах шинжээчээр ажиллаж болно.</p> <p>56.1.Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо /цаашид "Хуульчдын эрхийг хамгаалах хороо" гэх/ нь Хуульчдын холбооны прокурор, өмгөөлөгчдийн болон бусад мэргэшлийн чиглэлээр байгуулагдсан хуульчдын хорооны төлөөлөгчдөөс бүрдсэн 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.</p> <p>56.2.Хуульчдын эрхийг хамгаалах хороонд прокурор, өмгөөлөгчдийн хорооны төлөөлөл тус бүр гурав, бусад хуульчдын хороодын нийт төлөөлөл дөрөв байна.</p> <p>56.5.Хуульчдын эрхийг хамгаалах хороо нь прокурорын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд Улсын ерөнхий прокурорын газартай, өмгөөлөгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд Өмгөөлөгчдийн хороотой хамтран комисс байгуулна.</p>		

2.3. УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Хуулийн төслийн нэр	Төслийн бичигдсэн хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Шүүх байгуулах тухай хууль	Тодорхойгүй	<ul style="list-style-type: none"> Хүн ам, газар нутаг, шүүгчийн ажлын ачааллыг харгалзан тойргийн шүүх байгуулж болох үндэслэл, журмыг нарийвчлан тогтоох; Шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, тойргийн зарчмаар шүүх байгуулах нь шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр чөлөөлөх, шилжүүлэх үндэслэл болохгүй байх зохицуулалтыг хуульчлах.

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН АКТ

3.1 УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Тогтоолын нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнээр томилох тухай	2021 оны 11 сарын 18-ны өдөр	Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108.1 дүгээр зүйлийн 108.1.3 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн сахилгын

		хорооны шүүгч бус гишүүнээр ажиллах гишүүдийг томилсон байна.
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай		
<p>2019 оны 11 дүгээр сарын 14-ний Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах тухай заасан бөгөөд “түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно” хэмээн тусгасан байдаг. Шүүхийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.5 дахь хэсэгт “Улсын Их Хурал нь энэ хуулийн 77.1, 77.2, 77.3, 77.4, 77.5, 77.6, 77.7, 77.8, 77.9, 77.10-т заасан журмыг баримтлан Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулж, томилно” гэж заасан.</p> <p>2021 оны 11 сарын 18 өдөр Улсын Их Хурал “Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнээр томилох тухай” тогтоол гаргасан нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаанд нийцүүлсэн байна.</p>		
Тогтоолын нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай	2021 оны 11 сарын 25-ны өдөр	Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүгч бус гишүүнээр ажиллах 4 гишүүнийг томилон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Э.Батбаярыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай		
<p>2019 оны 11 дүгээр сарын 14-ний Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно” хэмээн тусгагдсан.</p> <p>Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсэгт “Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно”, мөн тус хуулийн 76 дугаар зүйлийн 76.5 дахь хэсэгт “Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрх сонгогдож, томилогдсоноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно” гэж заасан ба Улсын Их хурлаас 2021 оны 11 сарын 25 өдөр гаргасан “ Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай” тогтоол нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаанд нийцүүлсэн нь харагдаж байна.</p>		
Тогтоолын нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох тухай	2021 оны 12 сарын 02 өдөр	Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр Дорждамбын Зүмбэрэлхамыг томилох
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай		
<p>Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт орсон нэмэлт өөрчлөлтийн болон Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсэгт “Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно” хэмээн заасны дагуу Улсын Их Хурал нь дээрх тогтоолыг нийцүүлэн гаргасан байна. 2021 оны 11 сарын 25 өдөр Улсын Их хурлаас гаргасан “ Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр</p>		

томилох, чөлөөлөх тухай” тогтоолд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 4 гишүүнийг томилох тухай тусгагдсан байсан бол энэ удаагийн тогтоолоор шүүгч бус гишүүнээр ажиллах таван гишүүний үлдсэн нэг гишүүнийг томилох тухай заагдсан байна. Энэ тогтоол нь Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт болоод Шүүхийн тухай хуулийн холбогдох зүйл заалтуудад нийцсэн байна.

ДӨРӨВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр “шүүхийн хараат бус байдлыг хангаж, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэхтэй холбоотой”-оор Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно”, дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.”, дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно” гэсэн зохицуулалтууд тус тус нэмэлт, өөрчлөлтөөр батлагдсан.

Ийнхүү Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-г 1) Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, 2) Шүүгчийн хариуцлагыг сайжруулах, 3) Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төслийн жагсаалтын баталсан билээ. Үүнд, Шүүхийн захиргааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Шүүхийн сахилгын хорооны тухай хууль /Анхдагч хууль/, Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг тус тус батална хэмээн тусгасан байсан. Гэвч хууль тогтоогчоос шүүхийн хараат бус байдлыг хангаж, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх 1) Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, 2) Шүүгчийн хариуцлагыг сайжруулах хоёр асуудлыг 2021 оны 01 сарын 15-ны өдөр Шүүхийн тухай хуулиар бүхэлд нь зохицуулсан байна. Харин шүүхийг тойргийн зарчмаар байгуулах талаарх зохицуулалттай холбоотой хууль, тогтоомж батлагдаагүй ба уг нэмэлт, өөрчлөлт одоогоор хэрэгжиж эхлээгүй байна.

VI. “ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА”-Д ХОЛБОГДОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭН ГАРАХ ХУУЛЬ, ТОГТООМЖИД ХИЙСЭН СУДАЛГАА

НЭГ. ТАНИЛЦУУЛГА ХҮСНЭГТ

ХУУЛЬ		
Нэг	ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА	
№	Хуулийн нэр	Батлагдсан хугацаа
1	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль ²⁹	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
2	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль ³⁰	2020 оны 12-р сарын 24-ны өдөр
Хоёр	НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ	
№	Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт оруулсан хугацаа
1	Газрын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
2	Хот байгуулалтын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
3	Газрын төлбөрийн тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
4	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
5	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
6	Төсвийн тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр, 2020 оны 12 сарын 24-ний өдөр, 2021 оны 12 сарын 24-ний өдөр
7	Өрийн удирдлагын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
8	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
9	Усны тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
10	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр

²⁹ Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230779072091>

³⁰ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801>

11	Нийслэл хотын албан татварын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
12	Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
13	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
14	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
15	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ны өдөр
16	Татварын ерөнхий хууль	2020 оны 12-р сарын 24-ны өдөр
Гурав	УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДСАН ХУУЛИЙН ТӨСӨЛ	
№	Төслийн нэр	Өргөн баригдсан хугацаа
1	Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль ³¹	тодорхойгүй
2	Хот байгуулах тухай хууль	2020 оны 1-р сарын 22-ны өдөр
3	Доорх хуулийн төслүүд нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор боловсруулсан хуулийн төслүүд бөгөөд УИХ-д 2022 оны 1-р сарын 5-ний өдөр өргөн баригдсан.	
3.1	Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	
3.2	Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	
3.3	Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	
3.4	Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
3.5	Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
3.6	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
3.7	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
3.8	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	

³¹ Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, <http://forum.parliament.mn/projects/10810>

3.9	Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.10	Ард нийтийн санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.11	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.12	Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.13	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.14	Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.15	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.16	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.17	Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.18	Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.19	Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.20	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.21	Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.22	Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.23	Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.24	Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.25	Галын аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.26	Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.27	Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.28	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.29	Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.30	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

3.31	Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.32	Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.33	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.34	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.35	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.36	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.37	Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.38	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.39	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.40	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.41	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.42	Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.43	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.44	Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.45	Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.46	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.47	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.48	Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.49	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.50	Монгол Улсын батлан хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
3.51	Монгол улсын их хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.52	Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

3.53	Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.54	Монгол улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.55	Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.56	Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.57	Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.58	Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.59	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.60	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.61	Нийтийн сонсголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.62	Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.63	Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.64	Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.65	Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.66	Орон сууц хувьчлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.67	Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.68	Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.69	Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.70	Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.71	Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.72	Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.73	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.74	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

3.75	Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.76	Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.77	Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль
3.78	Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.79	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.80	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.81	Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.82	Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.83	Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
3.84	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.85	Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.86	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.87	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.88	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.89	Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.90	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.91	Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.92	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.93	Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.94	Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.95	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.96	Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

3.97	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.98	Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.99	Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.100	Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.101	Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.102	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.103	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.104	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.105	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.106	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.107	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.108	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.109	Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хууль
3.110	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.111	Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.112	Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.113	Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.114	Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.115	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.116	Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
3.117	Цэргийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
3.118	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

3.119	Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	
3.120	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	
3.121	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	
3.122	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
3.123	Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	
3.124	Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	
3.125	Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	
3.126	Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	
4	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	2021 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр
Дөрөв	УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДААГҮЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	
№	Төслийн нэр	Бичигдсэн хугацаа
1	Дараах хууль тогтоомжууд нь Хот байгуулах тухай хуулийг дагалдан гарах хуулийн төслүүд бөгөөд Хот байгуулах тухай хуулийг Улсын Их Хуралд 2020 оны 1-р сарын 22-ны өдөр өргөн барьсан ч дагалдах хуулийн төслүүдийг өргөн барьсан гэх албан бичиг байхгүй байна.	
1.1	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
1.2	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
1.3	Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	
1.4	Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	
1.5	Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	
1.6	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
1.7	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
1.8	Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
1.9	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	
1.10	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	

1.11	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	
ЭРХ ЗҮЙН АКТ		
Нэг	УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ	
№	Тогтоолын нэр	Батлагдсан хугацаа
1	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай	2020 оны 12 сарын 17-ний өдрийн 45 дугаар тогтоол ³²
2	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам батлах тухай	2022 оны 1-р сарын 18-ний өдрийн 07 дугаар тогтоол ³³

ХОЁР. ХУУЛЬ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 1-р сарын 9-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар³⁴ “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсн.

Уг хуваарийн дөрөвдүгээр хэсэгт нь “нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлт” тусгагдсан бөгөөд 4.1 дэх хэсэгт **Хот, тосгоны эрх зүйн байдлыг тодорхой болгох нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд** “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны эрх зүйн үндэс, тэдгээрийн өөрийн удирдлагын болон засаг захиргааны зохион байгуулалтын зарчмыг хуулиар тогтоож, хот, тосгоны өөрийн удирдлагыг оршин суугчид нь сонгож, хот, тосгоны удирдлагад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын болон төсөв, санхүүгийн зарим эрх мэдлийг шилжүүлэх, удирдлагын давхардал, хийдлийг арилгах, хотын нийтийн үйлчилгээг оршин суугчдад, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, эдийн засгийн хувьд хот, тосгон харьцангуй бие даан хөгжих боломжийг бүрдүүлэх” гэсэн чиглэлийг баримтлахаар тусгасан бол 4.2 дахь хэсэгт **Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд** “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг тухайн нутгийн иргэдийн саналд үндэслэн шийдвэрлэх зарчмыг хэвээр хадгалж, уг асуудлыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүргийг Засгийн газар хүлээх” 4.3 дахь хэсэгт **Нутгийн өөрөө удирдах ёсны эрх зүйн үндсийг тогтоох нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд** “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны чөлөө цагт тухайн Хурлын Тэргүүлэгчид нь Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлж ирсэн тогтолцоог халж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шаардлагатай тохиолдолд хуралдаж асуудлаа шийдвэрлэж байх”, “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоож байхаар зааж, тэдгээрийн чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоох эрх зүйн үндсийг бүрдүүлэх”, “аймаг, нийслэл, сум, дүүргийн эрх зүйн

³² “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их хурлын 2020 оны 12 сарын 17-ны өдрийн 45 дугаар тогтоол <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230555588101> [Сүүлд үзсэн: 2022.02.21]

³³ “Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам батлах тухай” Улсын Их хурлын 2022 оны 01 сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390150734701> [Сүүлд үзсэн: 2022.02.22]

³⁴ “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их хурлын 2020 оны 1-р сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14950> [Сүүлд үзсэн: 2022.02.22]

байдал, өмчийн болон төсвийн харилцааг тусгайлсан хуулиар ялгамжтай зохицуулах, аймаг, нийслэл, сум, дүүрэг бие даан хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор татварын хуваарилалтын зарчмыг шинэчлэх, орон нутагт ногдох татварын суурийг өргөтгөх”, “шинэчлэн боловсруулсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиудад салбарын бусад хууль тогтоомжийг нийцүүлэх” гэсэн чиглэлийг баримтлан хуульчлахаар тогтоосон байна.

Уг хуваарийн дагуу шинэчлэн найруулахаар төлөвлөгдсөн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль(1), Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль(2), Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай(3) Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай(4) Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай(5) Татварын ерөнхий хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай(6) хуулиудын талаар тодруулбал дараах байдалтай байна.

2.1. ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

Хуулийн нэр	Батлагдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 оны 12 сарын 24-ны өдөр	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэг, эдийн засгийн үндэс, нэгжийг өөрчлөх үндэслэл журам, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх өөрийн болон төрийн удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, нутгийн өөрийн удирдлагын байгууллагын эрх хэмжээ, зохион байгуулалт, бүх шатны Засаг даргын бүрэн эрх, нутгийн удирдлагаас бусад байгууллагатай харилцах харилцаа болон хот, тосгоны өөрийн удирдлагад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах
<p align="center">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, тэргүүлэгч, төлөөлөгчдийн саналыг сонсож, төсөлд тусгах зорилготой цахим хэлэлцүүлгийг 2020 оны 12-р сарын 8-ний өдөр Улсын Их Хурлын Нутгийн удирдлагын дэд хорооноос зохион байгуулсан³⁵ бөгөөд хэлэлцүүлгийн эхэнд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлж, байр сууриа илэрхийлсэн бөгөөд тэр бээр 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Үндсэн хуульд оруулсан нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлт нь:</p> <p>Нэгдүгээрт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тогтолцоог зохистой болгон, төвлөрлийг сааруулж, нутгийн захиргааг бэхжүүлэх эрх зүйн үндсийг сайжруулсан.</p> <p>Хоёрдугаарт, нутгийн өөрөө удирдах байгууллагын орлогоо өөрөө бүрдүүлэх, төсөв, санхүү, татвар, өмчийн эрх мэдлийг тодорхой болгож, өргөжүүлснээр орон нутгийн бие даан хөгжих боломжийг дэс дараатай бүрдүүлэхийг зорьсон.</p> <p>Гуравдугаарт, хот, тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтоож, тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим эрх хэмжээг шилжүүлэх болсноор удирдлагын бүтцийн давхардлыг арилгаж, хөдөө хөгжих, хот тосгон төлөвшин хөгжих нөхцөлийг бүрдүүлсэн ач холбогдолтой болсон гэж үзэж байна хэмээгээд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг батлан гаргахдаа орон нутаг нь өмчийг эзэмших, захиран зарцуулах, орлого олох, татвар ногдуулах, эдийн засгийн хувьд чадавхтай, өөрөөр хэлбэл</p>		

³⁵ “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төлсөл <http://forum.parliament.mn/projects/10803> [Сүүлд үзсэн: 2022.02.25]

нутгийн олон түмний эрх ашгийг хамгаалах, асуудлыг шийдэх эрх хэмжээтэй байх нь Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн гол агуулга гэж ойлгох нь зүйтэй³⁶ гэсэн байна.

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан. Бөгөөд үүний дагуу Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэлэлцэн баталсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн³⁷. Түүнчлэн 2022 оны 1-р сарын 5-ны өдөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор боловсруулсан 126 хуулийн төслүүдийг/өмнөх хэсэгт буюу УИХ-д өргөн барьсан хуулийн төслүүдэд дурдагдсан/ УИХ-д өргөн барьсан байна.

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсгийг тухайн нутгийн хурлын саналыг үндэслэх шаардлагыг хассан бөгөөд Засгийн газар өргөн мэдүүлснээр гэж процедурыг илүү тодруулсан. Энэхүү өөрчлөлт нь төр засгийн үйл хэрэгт иргэдийн оролцоог хангах ардчиллын үндсэн зарчмыг хэвээр хадгалж, нутгийн хурлын санал нь тухайн нутгийн иргэдийн саналтай адил байх ёстой хэмээн үзэж, иргэдийн саналыг хэвээр хадгалж, тухайн нутгийн хурлын саналыг үндэслэх гэснийг хасаж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх процедурыг илүү хялбарчилсан. 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг тухайн орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ” хэмээн хуульчилсан байна. Үүнээс харахад аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг Засгийн газар санаачлах бөгөөд ингэхдээ тухайн орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан тухайн нэгжийн “иргэдийн санал”-ийг авсан байхаар хуульчилжээ. Харин баг, хороог өөрчлөх асуудлыг тухайн нэгжийн Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн нутгийн Хурал шийдвэрлэхээр уг хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт хуульчилсан байна. Энэ нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хуульчлагдсан 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсгийн зохицуулалтыг материаллаг хуулиар илүү нарийвчлан тогтоосон зохицуулалт болсон байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн тавин наймдугаар зүйлд аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар олгогдсон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор гэж үзсэн бөгөөд Б.Чимид профессор баг, хороог жам ёсоор³⁸ бий болох нэгж тул баг, хороо нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах боловч статус нь аймаг, нийслэл, сум, дүүргээс ялгаатай байна хэмээн үзсэн³⁹ байдаг. ЗЗНДНТУТХ-д аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэж, баг, хороог өөрчлөх асуудлыг Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн нутгийн Хурал шийдвэрлэхээр зохицуулсан нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн гэж үзэж болохоор байна.

Мөн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ” хэмээн өөрчилж улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот хэмээн хотын ангиллыг нэмж хотыг зөвхөн Улсын нийслэл Улаанбаатар хотоор хязгаарлахаа больсноор өмнө нь “Дархан, Эрдэнэт, Чойр” зэрэг улсын харьяалалтай хотууд аймаг болж төсвийн захиран зарцуулалт, удирдлагын давхцал, эрх мэдлийн хуваарилалт оновчгүй, ойлгомжгүй байдал, үйл ажиллагааны зохион байгуулалт тодорхойгүй, хүн амын шилжилт хөдөлгөөн ихсэх, хотын төвлөрөл үүсэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэх үндэс болсон. Тэгвэл ЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулгаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөгдөн хуульчлагдсан 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийг үзэл санааг дэлгэрүүлэн хуульчилсан байна.

Тодруулбал, ЗЗНДНТУТХ-ийн дөрөвдүгээр бүлэг нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг хот, тосгонд шилжүүлэх тухай асуудлыг зохицуулсан байна. Уг хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар

³⁶ “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн цахим хэлэлцүүлгээр орон нутгийн удирдлагуудын саналыг сонслоо”, мэдээ, <http://www.parliament.mn/n/4hbyn> [Сүүлд үзсэн: 2022.02.25]

³⁷ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2020)

³⁸ Чимид Б., *Үндсэн хуулийн мэдлэг*, УБ, 355 дахь тал

³⁹ Гангабаатар Д., *Үндсэн хуулийн эрх зүй: төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал*, УБ, 2019, 162 дахь тал

зүйн байршил, дэд бүтэц, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ” гэсэн байх бөгөөд 68.2 дахь хэсэгт уг чиг үүргийг шилжүүлэхэд шаардлагатай санхүүжилт олгох үүргийг төр хүлээхээр хуульчилсан байна. Түүнчлэн уг хуулийн 69 дүгээр зүйлд “Улсын зэрэглэлтэй хот, Орон нутгийг зэрэглэлтэй хот, Тосгон”-нд аймаг, сум, багийн ямар чиг үүргийг шилжүүлж болох талаар нарийвчлан зохицуулсан байна. Эдгээр зохицуулалт нь дээр дурдсанчлан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг нарийвчлан зохицуулсан бөгөөд 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсгийг “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно” хэмээн өөрчилж нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан цогцолбор байх Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалыг тодотгож өгсөн бөгөөд уг заалтыг баталснаар нутгийн өөрийн удирдлагын үндсэн нэгжийг Үндсэн хуулийн түвшинд тодорхойлно(1) Сум, дүүргийн ИТХ хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхийг эдэлнэ(2) Нутгийн өөрийн удирдах байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгана(3) Орон нутаг дахь хэт улс төржилтийг сааруулна(4) Удирдлагын хэт төвлөрлийг сааруулах боломж бүрдэнэ(3)⁴⁰ хэмээн үзэж байна. Тэгвэл ЗЗНДНТУтХ-ийн шинэчилсэн найруулгаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөгдөн хуульчлагдсан 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсгийг үзэл санааг дэлгэрүүлэн хуульчилсан байна.

Тодруулбал, Нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлдэг субъектуудыг Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 болон Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.5-т “...аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн иууд оролцоо бүхий иргэдийн Нийтийн Хурлыг...” гэж тодорхойлсон байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөгдөн хуульчлагдсан 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсгийн “аймаг, нийслэл иргэдийн төлөөлөгчдийн хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй” гэснийг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд дараах байдлаар дэлгэрүүлэн зохицуулсан байна.

Өөрөөр хэлбэл ЗЗНТУтХ-ийн 18 дугаар зүйлд аймаг, сум, нийслэл, дүүргийн өмч гэсэн зохицуулалтыг тусгасан байх бөгөөд уг зүйлийн 18.1 дэх хэсэгт Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь өмчтэй байна хэмээн хуульчилсан байна. Энэ нь нутгийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь өөрийн гэсэн өмчтэй бие даасан байх гэсэн зохицуулалт бөгөөд 18.2 дахь хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга хэрэгжүүлнэ” хэмээн хуульчилж тухайн өмчийн өмчлөгчөөр тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, харин өмчийг захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлэгч нь Засаг дарга байхаар хуульчилж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэлгэрүүлэн, нарийвчлан зохицуулсан байна. Түүнчлэн ЗЗНТУтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсэгт “аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”, “орон нутгийн өмчийн харилцааг хуулиар зохицуулна” хэмээн хуульчилсан байна. Энэ талаар Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд мөн зохицуулсан байх бол орон нутгийн өмчийн харилцааг хуулиар зохицуулна гэж заасан нь уг хуулиар уу эсхүл өөр тусгай хуулиар дэлгэрүүлж зохицуулах эсэх нь тодорхой бус байна.

Харин Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөгдөн хуульчлагдсан 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно” гэснийг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлд засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв хэмээн тусгаж зохицуулсан байна. Тодруулбал, уг зүйлийн 16.1 дэх хэсэгт “аймаг, сум, нийслэл, дүүрэг нь бие даасан төсөвтэй байна”, 16.2 дахь хэсэгт “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн эх үүсвэр нь татварын болон татварын бус орлого, улсын төсвийн санхүүжилт, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс бүрдэнэ” 16.3 дахь хэсэгт “аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгийг энэ хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулна” 16.4 дэх хэсэгт “сум, дүүргийн төсвийг боловсруулж, батлахдаа харьяалах баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас гаргасан саналыг авч тусгана. Баг, хорооны үйл ажиллагааны зардлыг харьяалах сум, дүүргийн төсөвт тусгайлан батална” хэмээн хуульчилсан байна. Төсвийн хувьд бие даасан байна гэдэг нь бусад гуравдагч этгээдээс хамааралгүй байхыг ойлгох бөгөөд хуулиар зөвшөөрөгдсөн

⁴⁰ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, саналын талаарх хэлэлцүүлэг (Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо), УБ, 2019, 99 дэх тал

<p>бусад эх үүсвэр гэдэг нь энэ хууль болон бусад холбогдох хуульд зөвшөөрөгдсөн эх үүсвэр байна. Өөрөөр хэлбэл хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад эх үүсвэрээс төсвөө бүрдүүлэх боломжгүй ба энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд л зөвхөн төсвийн хөрөнгийг захиран зарцуулахаар дээрх заалтууд хуульчлагдсан байна. Түүнчлэн эдгээр заалтууд нь орон нутагт амьдарч буй иргэдийн шууд төлөөлөл болдог Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Иргэдийн нийтийн хурлын эрх хэмжээг баталгаажуулсан зохицуулалт байх тул Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн хэмээн үзэж болохоор байна.</p>		
Хуулийн нэр	Батлагдах хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
<p>Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/</p>	<p>2021 оны 7-р сарын 7-ны өдөр</p>	<p>Нийслэл Улаанбаатар хотын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, үйл ажиллагааны зарчим, удирдлагын эрх хэмжээ, нийслэл хотын удирдлагаас төрийн дээд, төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон бусад этгээдтэй харилцах эрх зүйн үндсийг тодорхойлох</p>
<p style="text-align: center;">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ний өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Нийслэл хот нийгэм, эдийн засгийн хувьд бие даан хөгжих хөшүүргийг бий болгох, хүн амын төвлөрлийг сааруулах, нийслэлийг нэг төвт хотоос олон төвт, орчин үеийн хот болгон хөгжүүлэх, нийслэлийн дагуул хот, тосгодыг хөгжүүлэх, нийслэлийн удирдлагын эрх зүйн байдлыг боловсронгуй болгоход 7 бүлэг, 51 зүйл бүхий Уг хуулийн үзэл баримтлал чиглэсэн⁴¹ бөгөөд уг хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасанчлан хуулийн зорилт нь “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын тусгай болон бусад чиг үүргийг тогтоох, хөгжлийн бодлого, удирдлага, зохион байгуулалтын онцлог, дагуул хот, эдийн засгийн тусгай бүс, төрийн дээд болон төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, хуулийн этгээд, байгууллагатай харилцахтай холбогдсон харилцааг” зохицуулахад оршиж байна.</p> <p>Уг хуулийн нэгдүгээр бүлэгт Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нийслэл хотын зохион байгуулалтын үндэс, нийслэл хотыг хөгжүүлэх бодлого, нийслэл хотын эдэлбэр газар, бүсчлэлтэй холбоотой харилцааг тусгасан бол хоёрдугаар бүлэгт нийслэл хотын чиг үүрэг, нийслэлийн дүрмийн талаар, гуравдугаар бүлэгт нийслэл хотын эдийн засгийн харилцааны талаар, дөрөвдүгээр бүлэгт нийслэлийн удирдлагын тогтолцоо, бүрэн эрх, ажлын уялдааны талаар, тавдугаар бүлэгт нийслэлээс бусад этгээдтэй харилцах харилцааны талаар, зургадугаар бүлэгт нийслэл хотын дагуул хот болон эдийн засгийн тусгай бүсийн талаар, долдугаар бүлэгт нийслэлийн үйл ажиллагаа, удирдлагаас гаргаж буй шийдвэр болон төсөв санхүү нээлттэй, ил тод байх, нийслэлийн гадаад хамтын ажиллагаа, нийслэл хотын өдөр, нийслэлийн шагналын талаар болон хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар тусгалаа тусгасан байна.</p> <p>2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ” хэмээн өөрчилж улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот хэмээн хотын ангиллыг нэмж хотыг зөвхөн Улсын нийслэл Улаанбаатар хотоор хязгаарлахаа больсноор өмнө нь “Дархан, Эрдэнэт, Чойр” зэрэг улсын харьяалалтай хотууд аймаг болж төсвийн захиран зарцуулалт, удирдлагын давхцал, эрх мэдлийн хуваарилалт оновчгүй, ойлгомжгүй байдал, үйл ажиллагааны зохион байгуулалт тодорхойгүй, хүн амын шилжилт хөдөлгөөн ихсэх, хотын төвлөрөл үүсэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэх үндэс болсон. Тэгвэл Монгол Улсын нийслэл</p>		

⁴¹ “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар мэдээлэл сонсов”, мэдээ, <http://www.parliament.mn/n/iwzyn> [Сүүлд үзсэн: 2022.02.26]

Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөгдөн хуульчлагдсан 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийг үзэл санааг дэлгэрүүлэн хуульчилсан байна.

Тодруулбал, Нийслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болохын хувьд Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд заасан чиг үүргээс гадна нийслэл хотын хувьд хэрэгжүүлэх тусгай болон хотын аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлэх бусад чиг үүргийг уг хуулийн 8 дугаар зүйлд хуульчилсан байна. Ингэснээр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын статус буюу бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотоос ялгагдах тусгайлсан чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн байдал тодорхой болж, төсвийн захиран зарцуулалт, удирдлагын давхцал, эрх мэдлийн хуваарилалт оновчгүй, ойлгомжгүй байдал, үйл ажиллагааны зохион байгуулалт тодорхой байдал зэрэг асуудлууд шийдэгдэхээр болсон байна. Мөн уг хуулийн зургадугаар зүйлд нийслэл хотын дагуул хот болон эдийн засгийн тусгай бүс байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхээр холбогдох зохицуулалтыг тусгажээ. Нийслэл хотын дагуул хот нь эдэлбэр газартай байж, хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, тээвэр, логистикийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, газар зүйн байрлал болон нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдолтой, дэд бүтэц бүхий төвлөрсөн суурин газар байхаар тодорхойлсон байна. Түүнчлэн дагуул хотыг байгуулах, түүний чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын талаар нарийвчлан тусгасан байна. Ингэснээр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотыг олон төвт хот болгох, хүн амын болон дэд бүтцийн хэт төвлөрлийг сааруулах, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, дагуул хот, эдийн засгийн тусгай бүсэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх юм. Мөн уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт төрийн өмнөөс хэрэгжүүлж байгаа чиг үүргийг “тусгай чиг үүрэг” болгон тодорхойлж, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх гэх мэт төрийн дээд, төрийн захиргааны төв байгууллага, гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хуульд өөрөөр заагаагүй бол үндэсний болон олон улсын хэмжээний баяр наадам, хурал, урлаг, спортын болон бусад арга хэмжээг зохион байгуулах, олон улсын зорчигч болон ачаа тээвэр, логистикийн үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт болон нийслэл дэх үндэсний хэмжээний түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалт, нийслэлийн нутаг дэвсгэр дэх голын хамгаалалт, тохижилт, нийслэлийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын чанартай авто зам барих, түүнийг арчлалт, засвар, холбогдох үйл ажиллагаа, нийслэл хотын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, нийслэл хотын тусгай чиг үүрэг хэрэгжүүлэхэд шаардлагатай барилга, байгууламж, авто зам, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлэг болон бусад дэд бүтцийн засвар, арчлалт, цэвэрлэгээ, үйлчилгээ, хамгаалалт зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчилсан байна. Энэ нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн хэмээн үзэж болохоор байна.

2.2. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛЬ

Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Газрын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ы өдөр
<p align="center">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар</p> <p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр баглагдаж 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж газрын тухай хуульд өөрчлөлт орсон.</p> <p>Өөрчлөлтийг тодруулбал, Газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчилсөн.</p> <p>12.1.Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр газар, инженерийн дэд бүтэц, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийн газар, нийтийн эдэлбэрийн газар болон цаашид тэлж хөгжих нөөц газар хамаарна.</p>	

<p>12.2.Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна.</p> <p>12.3.Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газар нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрээс хилийн заагаар хязгаарлагдана.</p> <p>12.4.Нийслэл хот, түүний дагуул хот нь бүсчлэл бүхий эдэлбэр газартай байна.</p> <p>12.5.Нийслэл хотын дагуул хотын эдэлбэр газар нь бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн дагуул хотын эдэлбэр газарт газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газрын төлбөрийг дагуул хот байрлаж байгаа аймаг, сумын төсөвт төвлөрүүлнэ.</p> <p>12.6.Энэ хуулийн 12.4-т заасан эдэлбэр газрын бүсчлэлийг Засгийн газраас тогтоосон шалгуур үзүүлэлтийг үндэслэн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.”</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Хот байгуулах тухай хууль	2021 оны 7 сарын 7-ны өдөр
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар	
<p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ий өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж газрын тухай хуульд нэмэлт орсон.</p> <p>Нэмэлтийг тодруулбал, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “хугацаагаар” гэсний дараа “нээлттэй сонгон шалгаруулалт, нээлттэй сонсголын үндсэн дээр” гэж нэмсэн.</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Газрын төлбөрийн тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ы өдөр
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар	
<p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.</p> <p>Нэмэлт, өөрчлөлтийг тодруулбал,</p> <p>Газрын төлбөрийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмэгдсэн: 7 дугаар зүйлийн 9 дэх хэсэг: “9.Тусгай хамгаалалттай газар нутаг, нийслэлийн ногоон бүсэд аж ахуйн зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд стандартын шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж барьсан бол газрын төлбөрийг хоёр дахин нэмэгдүүлэн тооцож ногдуулна.”</p>	

<p>8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт: “13.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 39.1-д заасан чиглэлээр үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсэд эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний таван жилд 100 хувь, дараагийн гурван жилд 50 хувиар.”</p> <p>8 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг: “4.Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ногоон бүсэд газар эзэмшиж, ашиглаж буй иргэн энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасан газрын төлбөрийн хөнгөлөлтийг эдлэхдээ стандартын шаардлагад нийцээгүй нүхэн жорлонгүй байх нөхцөлийг хангасан байна. 5.Газрын төлбөрөөс хөнгөлөгдөж, чөлөөлөгдсөн иргэн, хуулийн этгээд газрыг зориулалтын дагуу эзэмшиж, ашиглаагүй нь тогтоогдвол хөнгөлж, чөлөөлсөн газрын төлбөрийг төсөвт нөхөн төлүүлнэ.”</p> <p>9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг: “7.Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан газрын төлбөрийг хоёр дахин нэмэгдүүлж ногдуулах, 8 дугаар зүйлийн 4 дэх заалтад заасан газрын төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх журмыг Нийслэлийн Засаг дарга, газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нар хамтран батална.”</p> <p>10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг: “6.Нийслэл хотын дагуул хотын эдэлбэр газар бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрт хамаарч байгаа тохиолдолд тухайн эдэлбэр газарт холбогдох газрын төлбөрийг оршин байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсөвт төлнө.”</p> <p>Мөн Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “сум, дүүргийн” гэснийг “аймаг, нийслэлийн” гэж, 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын “өмчийн хэлбэр харгалзахгүйгээр улсын бүртгэлтэй” гэснийг “төрийн болон орон нутгийн өмчийн” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалтын “чөлөөт бүсэд” гэснийг “чөлөөт бүс, нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсэд” гэж тус тус өөрчлөгдсөн.</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ы өдөр
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар	
<p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ий өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.</p> <p>Нэмэлт, өөрчлөлтийг тодруулбал, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд “7.1.6.нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсэд бүртгэгдсэн барилга байгууламж.” гэх заалт нэмэгдсэн бөгөөд Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “0.6-1.0” гэснийг “0.6.-2.0” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг “иргэн, хуулийн этгээдийн өмчилж байгаа аймаг, суман дахь орон сууц, нийслэл дэх хоёр орон сууц;” гэж өөрчилсөн.</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ы өдөр
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар	
<p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар</p>	

<p>сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт орсон.</p> <p>Нэмэлтийг тодруулбал, уг хуулийн 9 дүгээр зүйлд “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 39.1-д заасан чиглэлээр нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэх бол тухайн аж ахуйн нэгжийг төрөөс тэргүүн ээлжид дэмжинэ.” гэх 9.5 дахь хэсэг нэмсэн.</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Төсвийн тухай хууль	2021 оны 7-р сарын 07-ы өдөр,
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар	
<p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ий өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Төсвийн тухай хуульд 2021 оны 7-р сарын 7-ы өдөр өөрчлөлт орсон.</p> <p>Өөрчлөлтийг тодруулбал, уг хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийн “27 дугаар зүйлд” гэснийг “27 дугаар зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.2-т ” гэж өөрчилсөн.</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Өрийн удирдлагын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ы өдөр
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар	
<p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.</p> <p>Нэмэлт, өөрчлөлтийг тодруулбал, Өрийн удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмэгдсэн:</p> <p>4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалт: “4.1.24.“аймаг, нийслэлийн үнэт цаас” гэж аймаг, нийслэлээс тодорхой төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу дотоодын зах зээлд олон нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд арилжаалах өрийн бичгийг”</p> <p>“28¹ дүгээр зүйл. Аймаг, нийслэл үнэт цаас гаргах 28¹.1.Аймаг, нийслэл нь тодорхой төсөл, арга хэмжээ, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор үндэсний мөнгөн тэмдэгтээр дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно. 28¹.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь тухайн аймаг, нийслэлийн нэрийн өмнөөс үнэт цаас гаргагчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ. 28¹.3.Энэ хуулийн 28¹.1-д заасан төсөл, арга хэмжээ нь энэ хуулийн 18.5.1-18.5.4-т заасан шаардлагыг хангасан байна. 28¹.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга үнэт цаас</p>	

гаргах тухай саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаа танилцуулах бөгөөд дэмжсэн шийдвэр гарсан тохиолдолд төсвийн жил эхлэхээс 4-өөс доошгүй сарын өмнө санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж дүгнэлт гаргуулна. 28¹.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах шийдвэрийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан хязгаарт болон хуульд заасан нөхцөл, шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцсэн болохыг тогтоосон тохиолдолд жилийн төсвийн төслийг Засгийн газарт өргөн мэдүүлэхээс өмнө Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ. 28¹.6.Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргахад энэ хуулийн 19.1-д заасныг удирдлага болгох бөгөөд дараах шаардлагыг бүрэн хангасан байна: 28¹.6.1.Засгийн газраас үнэт цаас гаргах тухай зөвшөөрөл авсан байх; 28¹.6.2.Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээнд нийцсэн байх; 28¹.6.3.Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, зээллэгийн төлөвлөгөөнд нийцсэн, аймаг, нийслэлийн төсвийн төсөлд үнэт цаасаар хүлээх үүргийн хэмжээ, үнэт цаас гаргахтай холбогдсон зардлыг тусгасан байх; 28¹.6.4.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын энэ хуулийн 16.2-т заасны дагуу гаргасан дүгнэлт нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан хязгаарт болон хуульд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцсэн болохыг тогтоосон байх; 28¹.6.5.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах тухай Засаг даргын саналыг дэмжсэн байх; 28¹.6.6.хууль тогтоомжид заасан бусад. 28¹.7.Аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Засгийн газар баталж мөрдүүлнэ. 28¹.8.Аймаг, нийслэлийн үнэт цаасны төлбөрийг улсын төсвийн шилжүүлэг болон дэмжлэгээр төлөхийг хориглоно. 28¹.9.Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчиж аймаг, нийслэлийн үнэт цаас гаргахыг хориглоно.

Мөн Өрийн удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “6.2.2” гэсний өмнө “28¹ дүгээр зүйл” гэж, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “19” гэсний дараа “28¹” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.3 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах” гэж, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “Засгийн газрын” гэсний дараа “болон аймаг, нийслэлийн” гэж тус тус нэмсэн бөгөөд 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “19.11-д” гэснийг “19.11, 28¹ дүгээр зүйлийн 28¹.8, 28¹.9-т” гэж өөрчилсөн.

Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ы өдөр

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт орсон.

Нэмэлтийг тодруулбал, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмэгдсэн.

5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт: “5.1.3.Аймаг, нийслэлийн үнэт цаас;”

9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг: “9.2.Аймаг, нийслэлийн үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах бол Санхүүгийн зохицуулах хороонд хялбаршуулсан журмаар бүртгүүлэх бөгөөд үүнтэй холбоотой журмыг Хороо батална.”

10 дугаар зүйлийн 10.15.1 дэх заалт: “10.15.1.Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах;”

Мөн уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Засгийн газар,” гэсний дараа “нийслэл,” гэж нэмсэн.

Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
-------------	--------------------------------

Усны тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ы өдөр
<p style="text-align: center;">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар</p> <p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Усны тухай хуульд нэмэлт орсон.</p> <p>Нэмэлтийг тодруулбал, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “гэмдэгжүүлж,” гэсний дараа “хамгаалах, тохижуулах,” гэж нэмсэн.</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ы өдөр
<p style="text-align: center;">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар</p> <p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт орсон.</p> <p>Тодруулбал Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4-35.1.22 дахь заалт болон 35 дугаар зүйлийн 35.2.1-35.2.4 дэх заалтын хураамжийн хэмжээ өөрчлөгдсөн.</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Нийслэл хотын албан татварын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ы өдөр
<p style="text-align: center;">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар</p> <p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Нийслэл хотын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.</p> <p>Нэмэлт, өөрчлөлтийг тодруулбал, Нийслэл хотын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай</p>	

<p>дараах хэсэг, заалт нэмэгдсэн_</p> <p>4 дүгээр зүйлийн 4.1.8, 4.1.9 дэх заалт: “4.1.8.”автомашин угаалгын газар” гэж автомашины бохирдлыг цэвэрлэх иж бүрэн үйлчилгээ үзүүлэх байгууламжийг; 4.1.9.“авто үйлчилгээ үзүүлэгч” гэж нийтийн тээврээс бусад авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон үйлчилгээг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг.”</p> <p>7 дугаар зүйлийн 7.2.5, 7.2.6 дахь заалт: “7.2.5.энэ хуулийн 4.1.8-д заасан үйлчилгээ; 7.2.6.энэ хуулийн 4.1.9-д заасан үйлчилгээ.”</p> <p>Мөн Нийслэл хотын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “4.1.3-т” гэснийг “4.1.3, 4.1.8, 4.1.9-д” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэснийг “нийслэлийн Засаг дарга, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хамтран” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “0-1.0” гэснийг “0-2.0” гэж тус тус өөрчлөгдсөн.</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль	2021 оны 7-р сарын ы7-ний өдөр
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар	
<p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.</p> <p>Нэмэлт, өөрчлөлтийг тодруулбал, Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд “Албан татвар ногдох авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, бүртгэлээс хасах журмыг татвар, гааль, зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран батална.” 6.3 дахь хэсэг нэмэгдсэн. Мөн уг хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг хэмжээг өөрчилсөн.</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ы өдөр
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар	
<p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт орсон.</p>	

<p>Нэмэлтийг тодруулбал, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэгдсэн.</p> <p>12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг: “12.3.суурьшлын болон ногоон бүсээс 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.”</p> <p>17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг: “17.4.суурьшлын болон ногоон бүсээс 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.”</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	2021 оны 7-р сарын 7-ы өдөр
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар</p> <p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 7-ы өдөр батлагдаж 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт орсон.</p> <p>Нэмэлтийг тодруулбал, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд “Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгосон, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай мэдээллийг шийдвэрийн хамт шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор харьяа татварын албанд хүргүүлнэ.” гэх агуулгатай 12.7 дахь хэсэг нэмэгдсэн бөгөөд 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Тусгай зөвшөөрөл хүсэгч нь татварын өргүй, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлд заасан цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байна.” гэсэн агуулгатай 2 дахь өгүүлбэр нэмэгдсэн.</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа
Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль	2021 оны 7-р сарын 07-ы өдөр
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар</p> <p>Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааны санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд 2021 оны 07 дугаар сарын 07-ний өдөр батлагдаж 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуулийг дагалдаж Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт орсон.</p> <p>Өөрчлөлтийг тодруулбал, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10 дахь заалтын “Нийслэлийн” гэснийг “нийслэл хотын” гэж өөрчилсөн.</p>	
Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт орсон хугацаа

Татварын ерөнхий хууль	2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр
<p style="text-align: center;">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хэрхэн холбогдож буй талаар</p> <p>2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот” гэж нэмсэн бөгөөд 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсгийг “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно” хэмээн өөрчилж нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан цогцолбор байх Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалыг тодотгож өгсөн бөгөөд уг заалтыг баталснаар сум, дүүргийн ИТХ хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхийг эдлэх болсон. Үүний дагуу татварын ерөнхий хуульд 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орсон байна.</p> <p>Нэмэлт өөрчлөлтийг тодруулбал, Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.25 дахь заалтын "нийслэл" гэсний дараа "хот," гэж, 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийн "иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" гэсний дараа ",хотын Зөвлөл" гэж, 8.4 дэх хэсгийн "Хурал" гэсний дараа ",орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөл" гэж, 8.5 дахь хэсгийн "иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" гэсний дараа ",улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл" гэж, 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсгийн "нийслэл" гэсний дараа "улсын зэрэглэлтэй хот," гэж, 77.6 дахь хэсгийн "нийслэл" гэсний дараа "хот," гэж, 77.7.9 дэх заалтын "нийслэл" гэсний дараа "хот," гэж тус тус нэмсэн бөгөөд Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.25 дахь заалтын "сумын" гэснийг "сум, тосгоны" гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн, 46.5.1 дэх заалтын, 46.9 дэх хэсгийн, 47 дугаар зүйлийн 47.5.1 дэх заалтын "нийслэлийн" гэснийг "нийслэл, улсын зэрэглэлтэй хотын" гэж, 74 дүгээр зүйлийн 74.2 дахь хэсгийн "дүүргийн" гэснийг "дүүрэг, тосгоны" гэж, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн "нийслэлийн" гэснийг "нийслэл, улсын зэрэглэлтэй хотын" гэж, "сумын" гэснийг "сум, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны" гэж, 77.5 дахь хэсгийн "Засаг даргатай" гэснийг "Засаг дарга, хотын Захирагчтай" гэж, 77.8 дахь хэсгийн "Сумын" гэснийг "Сум, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны" гэж, "аймгийн" гэснийг "аймаг, хотын" гэж, "Засаг даргатай" гэснийг "Засаг дарга, хот, тосгоны Захирагчтай" гэж тус тус өөрчилсөн.</p> <p>Уг нэмэлт, өөрчлөлтийн дагуу Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 болон 8.3 дугаар зүйлд заасны дагуу Иргэдийн төлөөлөгчдийн хурал доор дурдсан татварын хувь хэмжээнд тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд Улсын их Хурлаас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэл болон сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.</p> <p>Аймаг, нийслэлийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> ● Хувь хүний орлогын албан татвар; ● Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар; ● Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар; ● Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж; ● Нийслэл хотын албан татвар; ● Нохойны албан татвар; ● Байгалийн ургамал ашигласны төлбөр; ● Рашаан ашигласны төлбөр; ● Ан амьтны нөөц ашигласны төлбөр; ● Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр. <p>Сум, дүүргийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> ● Малын тоо толгойн албан татвар; ● Хог хаягдлын үйлчилгээний хураамж байна. <p>Түүнчлэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасанчлан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоох хэмжээний хязгаарыг заасан байна.</p> <ul style="list-style-type: none"> ● Улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход 120 000-400 000 төгрөг; 	

- Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдээс бусад этгээдэд эмчилгээний гоо заслын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход 200 000-500 000 төгрөг;
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрлийг олгоход 150 000-250 000 төгрөг;
- Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;
- Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-1 000 000 төгрөг;
- Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход 100 000-500 000 төгрөг;
- Ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл олгоход 96 000-480 000 төгрөг;
- Ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд 32 000-160 000 төгрөг, гэрээг сунгахад 20 000-100 000 төгрөг;
- Усны барилга байгууламж гэрээгээр эзэмших, ашиглах эрх олгох, эрх сунгахад 40 000-200 000 төгрөг;
- Ан амьтныг эзэмших зөвшөөрөл олгоход 48 000-240 000 төгрөг;
- Нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход 40 000-200 000 төгрөг;
- Хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг олгоход 8000-40 000 төгрөг;
- Ан амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоход 1000-10 000 төгрөг;
- Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан агнах, барих гэрээ байгуулахад 400 000-2 000 000 төгрөг;
- Мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 толгой мал бол 1000-10000 төгрөг, 10-аас дээш тооны толгой мал бол 1000-10000 төгрөг дээр 10-аас дээш тооны малын толгой тутамд 50-200 төгрөг нэмж;
- Ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд 1200-6000 төгрөг;
- Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход 1000-4000 төгрөг;
- Элбэг ургамлыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд нойтон жингийн килограмм тутамд 4000-20000 төгрөг;
- Ойн дагалт нөөцийг ашиглах эрхийн бичиг олгоход 0-10 килограмм бол 1000-4000 төгрөг, 10 килограммаас дээш бол 10 килограммаас дээш тооцсон хэмжээний килограмм тутамд 50-200 төгрөг нэмж;
- Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн хуулийн этгээдэд олгоход 200 000-1 000 000 төгрөг, иргэнд 160 000-800 000 төгрөг;
- Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоход 80 000-400 000 төгрөг;
- Мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход 2000-10000 төгрөг;
- Рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход 125 000-640 000 төгрөг.
- Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

2.3. УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДСАН ХУУЛИЙН ТӨСӨЛ

Хуулийн төслийн нэр	Өргөн баригдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	Тодорхойгүй	Хот, тосгоны эрх зүйн үндсийг тодорхой болгож, тэдгээрийн өөрийн удирдлага, өмчийн болон төсвийн зохицуулалтыг нарийвчлан тусгах
<p align="center">Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын намрын чуулганы хугацаанд өргөн барихаар төлөвлөсөн бөгөөд орон нутгийн удирдлагуудаас төсөлд тусгах саналаа 2021 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн дотор Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлэх боломжтойг УИХ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс 2021 оны 9 сарын 28-ний өдөр мэдээлсэн⁴² гэхдээ уг хууль нь одоогоор батлагдаагүй байна.</p> <p>Түүнчлэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх цахим хэлэлцүүлгийг 2021 оны 9 сарын 28-ы өдөр зохион байгуулсан⁴³ бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хуулийн төслийг боловсруулахдаа улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын ялгааг тодорхойлох, хот, тосгон хоёрын эрх зүйн харилцаанд орох хязгаарыг тодорхой шалгуурын дагуу тогтоохыг зорьсон гэдгээ танилцуулсан байна⁴⁴.</p> <p>Монгол Улсын Үндсэн хуульд засаг захиргааны бүтцийг тодорхойлсон боловч Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар тогтоохоор заасан бөгөөд Улаанбаатар хот бол Монгол Улсын нийслэл хот мөн гэж томъёолсон нь төрийн захиргааны нэгж, хотын эрх зүйн байдал хоёр тусдаа байхаар эрх зүйн үндэслэлийг тогтоосон байна. Гэтэл одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хот, тосгоны эрх зүйн байдлын хуульд нутаг дэвсгэр дэх төрийн захиргааны нэгж, тухайн нутаг дэвсгэр дэх хот, тосгоны харилцааны нарийвчилсан зохицуулалтыг хийгээгүй орхигдуулснаас төрийн захиргааны нэгжийн удирдлага нь хот нийтийн аж ахуй, хөрөнгө төсөвт хэт хугалдан, төр аж ахуйн зааг ялгааг зөрчих явдал нэг талаас гарах, нөгөө талаас хот тосгон нь бүхий л ажил амьдралаа тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөллийн байгууллага, засаг даргын тамгын газарт даатган, хотын өөрийн удирдлагын үүрэг, зорилгыг алдагдуулах явдал нийтлэг⁴⁵ байдаг байна. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот” гэх өөрчлөлт орсноор холбогдох хууль тогтоомжууд өөрчлөлтийн үзэл санааг дэлгэрүүлэн шинэчлэгдэж буй бөгөөд үүний дагуу Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэгдэн батлагдахаар төлөвлөгдсөн байна. Одоогоор Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын Улсын Их Хурлын цахим хэлэлцүүлгийн сан буюу www.parliament.mn дээр хаагдсан гэсэн төлөвтэй байна⁴⁶.</p>		
Хуулийн төслийн нэр	Өргөн баригдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
		Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй

⁴² “Төрийн байгуулалтын байнгын хорооноос Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх цахим хэлэлцүүлгийг зохион байгууллаа”, мэдээ, <http://www.parliament.mn/n/hezon> [Сүүлд үзсэн: 2022.02.26]

⁴³ “Төрийн байгуулалтын байнгын хорооноос Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх цахим хэлэлцүүлгийг зохион байгууллаа”, мэдээ, <http://www.parliament.mn/n/hezon> [Сүүлд үзсэн: 2022.02.27]

⁴⁴ Мөн тэнд.

⁴⁵ Монгол Улсын Их Хурлын тамгын газар, *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа*, УБ.,2017, 370 дахь тал.

⁴⁶ http://forum.parliament.mn/projects/10810?fbclid=IwAR1_FRg411tZhhR5mb0dSTkx8S9W2X-J5lbJgsy_kP03O0wqWiYd5GV9MhU [Сүүлд үзсэн: 2022.02.22]

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	2021 оны 1-р сарын 07-ы өдөр	хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах
--	------------------------------	--

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсгийг “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно” хэмээн өөрчилж нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан цогцолбор байх Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалыг тодотгож өгсөн бөгөөд уг заалтыг баталснаар сум, дүүргийн ИТХ хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхийг эдлэх болсон.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэн батлахаар төлөвлөсөн 2020 оны 01 сарын 09-ний өдрийн УИХ-ийн 02 дугаар тогтоолын дагуу “нутгийн өөрөө удирдах ёсны эрх зүйн үндсийг тогтоох нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөл” нь “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоож байхаар зааж, тэдгээрийн чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоох эрх зүйн үндсийг бүрдүүлэх”, “аймаг, нийслэл, сум, дүүргийн эрх зүйн байдал, өмчийн болон төсвийн харилцааг тусгайлсан хуулиар ялгамжтай зохицуулах, аймаг, нийслэл, сум, дүүрэг бие даан хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор татварын хуваарилалтын зарчмыг шинэчлэх, орон нутагт ногдох татварын суурийг өргөтгөх” гэсэн үзэл баримтлалын дагуу боловсруулагдахаар тогтоосон. Үүний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөл боловсруулагдсан байна.

Тодруулбал, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн ёс дүгээр бүлэг нь “орон нутгийн өмчийн зүйлс” бөгөөд орон нутгийн өмчийн зүйлс нь уг төслийн 74 дүгээр зүйлс заасны дагуу нийтийн зориулалттай өмч болон орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэх бөгөөд Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид тухайн орон нутгийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан эд хөрөнгө хамаарахаар байна. Түүнчлэн орон нутгийн өмчид эд хөрөнгийг олж авах хэлбэрийг 75 дугаар зүйлс тусгасан байх бөгөөд 77 дугаар зүйлд орон нутгийн өмчийн талаарх иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхийг дараах байдлаар тогтоосон байна.

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.
2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;
3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;
4. Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө;
5. Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.
6. Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.
7. Хурлын Тэргүүлэгчид нь тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хариуцан тайлагнахаас гадна орон

<p>нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлнэ.</p>		
<p>Хуулийн төслийн нэр</p>	<p>Өргөн баригдсан хугацаа</p>	<p>Зохицуулах харилцааны товч утга</p>
<p>Хот байгуулах тухай хууль</p>	<p>2020 оны 1-р сарын 22-ний өдөр</p>	<p>Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хүн амын эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлсэн бүс нутаг хот суурийн газрыг төлөвлөх, байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах</p>
<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай</p> <p>Үндсэн хуулийн 2.2, 13.1, 57.1-д заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж зөвхөн аймаг, сум, багт хуваагдахаар зохицуулан, хотын асуудлыг зөвхөн нийслэл Улаанбаатар хотоор хязгаарласан тул, Дархан, Эрдэнэт, Чойр зэрэг Улсын харьяалалтай хотыг ялгаатай зохицуулах шаардлага үүссэн бөгөөд 1993 онд “хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хууль батлагдсаны дараа Дархан, Чойр, Эрдэнэт хотуудыг аймаг болгон зохион байгуулсан.⁴⁷ Үүнээс улбаалан олон асуудлууд Дархан, Чойр, Эрдэнэтын иргэдэд үүссэн. Дархан-Уул, Орхон аймгуудыг хотын статустай болгох асуудал иргэдийн дунд олон жил яригдсаар, энэ асуудлаар олон судалгаа дүгнэлт хийгджээ. Судалгаанаас үзэхэд Дархан-Уул, Орхон аймгуудын төвийн сумдыг (Дархан, Эрдэнэтийг) өнөөгийн хуулийн хүрээнд статусын хувьд хоттой харьцуулахад бүх талаараа харьцангуй жижиг нэгж болох сумуудтай (үүн дотор 1500 хүн амтай сумууд ч бий) нэг түвшинд байлгаж байгаа нь бодит байдал дээр ихээхэн бэрхшээлийг бий болгож байна. Тухайлбал, хотын захирагч нь тухайн аймгийн засаг дарга байснаараа хотын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой газар зохион байгуулалт, хот төлөвлөлт, хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ зэрэг олон үүрэг функцийг аймгийн удирдлагад шууд харьяалуулсан. Гэтэл иргэдэд үзүүлэх эдгээр үйлчилгээ нь үндсэндээ хотын хүрээний асуудлууд байдаг байна. Ингэснээрээ сумын (Дархан, Эрдэнэтийн) удирдлагын үүрэг багуудаар дамжуулан иргэдэд ойр зуурын үйлчилгээ үзүүлэх төдийгөөр хязгаарлагддаг⁴⁸ байсан байна. Харин 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот” хэмээн нэмж хот гэх ойлголтыг зөвхөн Улаанбаатар хотоор хязгаарлахаа болсноор дээрх асуудлууд шийдвэрлэгдэх үндэс тавигдсан бөгөөд уг зохицуулалттай холбоотойгоор буюу Үндсэн хуулийн үзэл баримтлалыг дэлгэрүүлэн зохицуулахаар Хот байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.</p> <p>Хот байгуулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хүн амын эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлсэн бүс нутаг хот суурийн газрыг төлөвлөх, байгуулахтай холбогдсон харилцаа зохицуулах зорилготой бөгөөд уг хуулийн төсөл нь 10 бүлэг, 60 зүйлтэй зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг шинээр тусгасан байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Хот байгуулах баримт бичгийг ач холбогдлоор нь ангилж түүнд тавигдах шаардлагыг нарийвчлан тусгасан, мөн тэдгээрт магадлал хийх үе шат, хот байгуулалтын баримт бичгийг хэрэгжүүлэх үе шат, тэдгээрт тавигдах шаардлага, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах болон хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийн талаар; 2. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, хот байгуулалтын бүсчлэл, түүнд тавигдах шаардлагыг одоо байгаа зохицуулалтаас илүү нарийвчлан тусгасан; 3. Хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч иргэн хуулийн этгээд, төрийн бусад байгууллагуудын чиг үүргийг тусгахаас гадна хот, суурины хүрээлэн буй орчин түүх, соёлын дурсгалт газрыг хадгалж хамгаалах, тэдгээрийн зохистой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн төлөвлөлтийн зохицуулалтыг тусгасан; 		

⁴⁷ Монгол Улсын Их Хурлын тамгын газар, *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар*, УБ., 2019, 139 дэх тал.

⁴⁸ Монгол Улсын Их Хурлын тамгын газар, *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа*, УБ., 2017, 369 дахь тал.

4. Хот байгуулалтын салбарын үйл ажиллагааг ялангуяа хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн хөгжил, хот төлөвлөлт, архитектур, хот байгуулалтын мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийх болон хот байгуулалтын баримт бичиг, төсөл хөтөлбөр боловсруулах, мэдээлэл, зөвлөмж өгөх чиг үүрэг судалгаа тооцоо, шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж байх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор бүс нутаг, хот төлөвлөлтийн хүрээлэн болон түүний чиг үүргийг тусгасан;
5. Мэргэжлийн байгууллагын эрх үүрэг, тавигдах шаардлага, хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах эрх олгох, хот байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд, мэргэжилтнүүдийн бүртгэлийг хөтлөн нэгдсэн мэдээллийн санд оруулж цахимжуулах зохицуулалтыг тусгасан;
6. Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, хүлээх хариуцлагыг томъёолон тусгаж, хот байгуулалтын талаарх төрийн байгууллагуудын эрх хэмжээ, үүрэг хариуцлагыг нарийвчлан тодорхойлсон байна.;

Түүнчлэн Хот байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар хот, суурин газар болон улс, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтийг хангах олон улсын жишигт нийцэх бөгөөд байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хууль зүйн хувьд дараах эерэг үр дагавар бий болгох ач холбогдолтой хэмээн хуулийн төслийг танилцуулгад дурдсан байна.

1. Бүс нутаг, хот, суурины хөгжлийн төлөвлөлт, бүтээн байгуулалтын үйл ажиллагааны талаарх бодлого, хэрэгжилтийн зохицуулалт нь нэгдмэл болж, хот байгуулалтын талаарх хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил арилна;
2. Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, хэрэгцээ, шаардлагад илүү нийцсэн, хүрээлэн буй байгаль орчинтойгоо харилцан холбоо бүхий ногоон хөгжлийн шаардлагыг хангасан, ногоон хот байгуулалт бий болгох нөхцөл бүрдэнэ;
3. Хот байгуулалтыг бүсчлэлийн хэлбэрээр зохицуулан холбогдох мэргэжлийн байгууллага, зөвлөлийн саналыг урьдчилж тусгах нь байгаль орчинд ээлтэй буюу хот, суурины нөөцийг оновчтой тооцоолсон, хөрөнгө оруулалтын бодлогод суурилсан, улсын хөгжлийн нэгдсэн бодлогод нийцсэн хот байгуулалтыг бий болгох нөхцөл бүрдэнэ;
4. Хот байгуулалтын баримт бичгийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газрын зохион байгуулалтын төлөвлөгөөг харилцан уялдуулах нь хот, суурины тэлэлт, шаардлагагүй дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, одоогийн үүссэн бүх хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ;
5. Үндсэн хуульд заасан “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн заалтын хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн эрх зүйн орчин бий болно;
6. Хот, тосгоны газар ашиглалтын зөв хуваарилалт бий болж, хот төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, түүний бүрэлдэхүүн хэсэг, хэрэгжүүлэх үе шат тодорхой болох эрх зүйн орчин бүрдэнэ;
7. Хот байгуулалтыг төлөвлөлтийн үе шатаас эхлэн хэрэгжүүлж дуусгах хүртэл хугацаанд хууль тогтоомж, норм, нормативын шаардлагыг хангаж ажиллах нөхцөл бүрдэнэ;
8. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН АКТ

3.1 УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Тогтоолын нэр	Батлагдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний	2020 оны 12 сарын 17-ний өдрийн 45 дугаар тогтоол ⁴⁹	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний

⁴⁹ “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их хурлын 2020 оны 12 сарын 17-ны өдрийн 45 дугаар тогтоол <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230555588101> [Сүүлд үзсэн: 2022.02.21]

удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай		удирдлагын тухай хуулийг хэрэгжилтийг хангах
--	--	--

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан уг хуулийг дагаж мөрдөх бэлтгэл ажлыг хангах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт Улсын Их Хурлаас энэхүү тогтоолоор даалгасан байна.

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан журмуудын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх;
2. Хотын албан татварын тухай анхдагч хуулийн төслийг 2021 оны эхний хагаст багтаан боловсруулж, өргөн мэдүүлэх;
3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох хуулийн төслийг өргөн мэдүүлэх;
4. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд захиргааны хэм хэмжээ тогтоосон актуудыг нийцүүлэх;
5. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах.

Тогтоолын нэр	Батлагдсан хугацаа	Зохицуулах харилцааны товч утга
Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам батлах тухай	2022 оны 1-р сарын 18-ы өдөр дугаар 07 ⁵⁰	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрхэн нарийвчлан зохицуулсан тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам"-ыг баталсан бөгөөд уг тогтоолыг 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосон байна. Журмын талаар тодруулбал дараах байдалтай байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулахад орших бөгөөд зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль тогтоомжийг дээдлэн, тухайн орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашиг, санал, хүсэлтийг харгалзан хамтын удирдлагын зарчмыг баримтлахаар тогтоосон байна. Түүнчлэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл байгуулахдаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй Зөвлөл байгуулахаар байна. Мөн уг журамд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны бэлтгэлийг хангах тухай дараах байдлаар зохицуулсан байна.

⁵⁰ “Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам батлах тухай” Улсын Их хурлын 2022 оны 01 сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390150734701> [Сүүлд үзсэн: 2022.02.22]

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3-т заасан ээлжит болон ээлжит бус хуралдааны тов, хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож Хурлын даргын захирамжаар батлуулах;
2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.2, 30.2.3, 31.1-д заасны дагуу иргэний гаргасан санал, санаачилгыг тухайн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх;
3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасан эрх бүхий этгээдээс санаачилсан асуудлыг Зөвлөлийн хурлаар урьдчилан хэлэлцэж, шаардлагатай тохиолдолд энэ журмын 4.1.4-т заасан арга хэмжээг авах;
4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Зөвлөлд ирүүлсэн материалыг хянаж, шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдээс тооцоо, судалгаа, лавлагаа, мэдээллийг гаргуулж авах.

Түүнчлэн уг журмын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасанчлан Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд 6.2, 6.3 дахь хэсэгт заасанчлан Зөвлөл Хурлын даргын товлосон өдөр, цагт хуралдах бөгөөд зөвлөл хуралдааны дэгээ өөрөө тогтооно. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хурлын дарга батлах бөгөөд гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр Зөвлөлийн хуралдаан хүчин төгөлдөр болохоор байна.

ДӨРӨВ. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгжтэй холбоотойгоор 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг, 57.3 дахь хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэг гэсэн гурван заалт өөрчлөгдсөн бөгөөд эдгээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн баталсан болон Улсын Их Хуралд өргөн баригдсан, Өргөн баригдахаар боловсруулсан хууль, хуулийн төслүүд, бусад хэм хэмжээний актуудыг энэхүү хэсэгт судаллаа. Судалгааны хүрээнд эдгээр хууль, хуулийн төсөл, бусад актуудыг нэгтгэн тодруулбал Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай гэсэн хоёр шинэчилсэн найруулга бүхий хууль батлагдсан бөгөөд 16 хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байна. Түүнчлэн Улсын Их Хуралд өргөн баригдсан 129 хууль байх бөгөөд эдгээрийн 126 хууль нь нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль бөгөөд үлдсэн гурван хууль нь Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хот байгуулах тухай хуулиуд байна. Харин Улсын Их Хуралд өргөн баригдаагүй нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 11 хуулийн төсөл байна. Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам батлах тухай Улсын Их Хурлын 2 тогтоолын чухал хэмээн үзэж тодруулан судалсан болно.

ДҮГНЭЛТ

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 сарын 09-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсан бөгөөд уг хуваарийн дагуу ямар хууль, эрх зүйн актууд батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон, эрх зүйн актын төсөл өргөн баригдсан гэдгийг судалгааны хүрээнд нарийвчлан судалсан болно. Үүнээс гадна 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хуульчлагдсан заалтууд болох Үндсэн хуулийн 6.2, 19¹, 21.4, 22.2, 22.3, 22.4, 25.1.6, 25.1.7, 25.1.16, 26.1, 27.2, 27.6, 27.7, 28.2, 29.3, 30.2, 33.4, 39, 43, 44, 48.1, 49.5, 49.6, 57.2, 57.3, 59.2 дугаар хэсгүүдтэй холбоотой батлагдсан болон өргөн баригдсан хууль, улсын их хурлын тогтоол, засгийн газрын тогтоолуудыг шүүн үзэж судалсан болно.

Тодруулбал, Монгол Улсын бүрэн эрхт байдалтай холбоотойгоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нэмэлт орсон бөгөөд үүнтэй холбогдуулан Монгол улсын хууль тогтоомжуудад заасан төрийн өмчийн зохицуулалтуудыг “төрийн нийтийн өмч” болгон өөрчлөх, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг батлах, байгалийн баялгийг ашиглах, баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг баталгаажуулах зэрэг асуудлуудыг хууль тогтоомжуудад тусгах шаардлага үүссэн. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн дагуу Үндсэн хуулийн 6.2-д орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан 7 хууль болон түүнтэй холбогдох бусад хууль тогтоомжийн шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлт, анхдагч хуулийг 2020 онд батлахаар төлөвлөсөн ч өнөөдрийн байдлаар Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Үндэсний баялгийн санд холбогдох хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиуд болон тэдгээрт холбогдох хуульд, нийт 20 хуулийн нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга, анхдагч хуулийн төслүүд боловсруулагдсан байна.

Хүний эрх, эрх чөлөөттэй холбоотойгоор Үндсэн хуулийн 19-р зүйлд “Арван ес дүгээр зүйл”-ийг нэмэлт өөрчлөлтөөр нэмсэн. Үндсэн хуулийн энэхүү нэмэлттэй холбогдуулан 2005 оны “Улс төрийн намын тухай” хуулийг шинэчлэн найруулах, “Улс төрийн санхүүжилтийн тухай” анхдагч хуулийн боловсруулах шаардлага, хэрэгцээ үүсэж “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т төлөвлөсөн.

Хууль тогтоох эрх мэдэлтэй холбоотойгоор 21 дүгээр зүйлийн 21.4 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.2, 3,4 дахь хэсгүүд, 25 дугаар зүйлийн 25.1.6, 7, 16 дахь хэсгүүд, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2, 6 дахь хэсгүүд, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг гэсэн заалтууд өөрчлөгдсөн. Эдгээр нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн баталсан болон Улсын Их Хуралд өргөн баригдсан, Өргөн баригдахаар боловсруулсан хууль, хуулийн төслүүд, бусад хэм хэмжээний актуудыг судалгааны хүрээнд нэгтгэн дүгнэвэл, анхдагч хууль 1, шинэчлэн найруулсан хууль 5, нэмэлт өөрчлөлт оруулсан хууль 5, Улсын их хурлын тогтоол 1, Улсын их хуралд өргөн баригдаагүй байгаа хуулийн төсөл 1, нийт 13 эрх зүйн акт байна.

Гүйцэтгэх эрх мэдэлтэй холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахаар төлөвлөгөөнд тусгасан байна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр шинэчлэн баталж, Засгийн газрын тухай хуульд мөн өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Шүүх эрх мэдэлтэй холбоотойгоор Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 49 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг гэсэн заалтууд тус тус нэмэлт, өөрчлөлтөөр батлагдсан. Эдгээр нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүхийн сахилгын хорооны тухай хууль, Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн батална хэмээн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т тусгасан болов ч хууль тогтоогчоос шүүхийн хараат бус байдлыг хангаж, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх, Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах,

Шүүгчийн хариуцлагыг сайжруулах зэрэг асуудлыг зөвхөн Шүүхийн тухай хуулиар бүхэлд нь зохицуулсан байна. Харин шүүхийг тойргийн зарчмаар байгуулах талаарх зохицуулалттай холбоотой хууль, тогтоомж батлагдаагүй ба уг нэмэлт, өөрчлөлт одоогоор хэрэгжиж эхлээгүй байна.

Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгжтэй холбоотойгоор 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг, 57.3 дахь хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэг гэсэн гурван заалт өөрчлөгдсөн бөгөөд эдгээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн баталсан болон Улсын Их Хуралд өргөн баригдсан, Өргөн баригдахаар боловсруулсан хууль, хуулийн төслүүд, бусад хэм хэмжээний актуудыг судалгааны хүрээнд нэгтгэвэл, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай гэсэн хоёр шинэчилсэн найруулга бүхий хууль батлагдсан бөгөөд 16 хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байна. Түүнчлэн Улсын Их Хуралд өргөн баригдсан 129 хууль байх бөгөөд эдгээрийн 126 хууль нь нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль бөгөөд үлдсэн гурван хууль нь Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хот байгуулах тухай хуулиуд байна. Харин Улсын Их Хуралд өргөн баригдаагүй нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 11 хуулийн төсөл байна. Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсан байна.

ЭХ СУРВАЛЖ

Хууль:

- Монгол Улсын Их Хурлын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/15441>
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/14869>
- Монгол улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/15412>
- Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390162361921>
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, <https://old.legalinfo.mn/law/details/15826>
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/344>
- Монгол Улсын Үндсэн хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
- Монгол Улсын Шүүхийн тухай, <https://old.legalinfo.mn/law/details/16047>
- Хууль тогтоомжийн тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/11119>
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/15403>
- Төрийн аудитын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/15357>
- “Улс төрийн намын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл 2021 он

Тогтоол шийдвэр:

- “Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам батлах тухай” Улсын Их хурлын 2022 оны 01 сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390150734701>
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, <https://legalinfo.mn/mn/detail/15586>
- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230779072091>
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801>
- Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, <http://forum.parliament.mn/projects/10810>
- “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их хурлын 2020 оны 12 сарын 17-ны өдрийн 45 дугаар тогтоол <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230555588101>
- “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их хурлын 2020 оны 1-р сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14950>

- “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их хурлын 2020 оны 12 сарын 17-ны өдрийн 45 дугаар тогтоол <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230555588101>
- Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнээр томилох тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381511093001>
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай, <https://old.legalinfo.mn/law/details/17041?lawid=17041>
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389648521281>

Хуулийн төсөл, үзэл баримтлал:

- Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, <http://forum.parliament.mn/projects/11204> [Сүүлд үзсэн: 2022.03.22]
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, (shorturl.at/kpyDE) [Сүүлд үзсэн: 2022.03.22]
- “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төлсөл <http://forum.parliament.mn/projects/10803> [Сүүлд үзсэн: 2022.02.25]
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн төсөл, <http://forum.parliament.mn/projects/11114> [Сүүлд үзсэн: 2022.03.22]
- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, (shorturl.at/nCDRW) [Сүүлд үзсэн: 2022.03.22]
- Хууль зүй, дотоод хэргийн яам “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал” 2021.04.26, [Topic: Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай /Шинэчилсэн найруулга/ | Хууль зүй, дотоод хэргийн яам](http://forum.parliament.mn/projects/10803) [Сүүлд үзсэн: 2022.02.21]

Бусад (ном, сурах бичиг, өгүүлэл, мэдээ):

- Чимид Б., Үндсэн хуулийн мэдлэг, УБ
- Гангабаатар Д., Үндсэн хуулийн эрх зүй: төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, УБ, 2019
- “Ерөнхийлөгч Х.Баттулга дахин нэр дэвших боломжтой юу?” 2020.02.07 - нийтлэл, www.news.mn
- “Монгол Улсын Ерөнхий сайдыг нэр дэвшүүлэхээр зөвшилцөх саналыг өргөн барьлаа,” мэдээ, 2020.07.01, <https://president.mn/14757/>
- “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн цахим хэлэлцүүлгээр орон нутгийн удирдлагуудын саналыг сонслоо” , мэдээ, <http://www.parliament.mn/n/4hbyn>
- Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, саналын талаарх хэлэлцүүлэг (Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо), УБ, 2019, “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар мэдээлэл сонсов”, мэдээ, <http://www.parliament.mn/n/iwzyn>
- Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 02 дугаар дүгнэлт, <https://old.legalinfo.mn/law/details/16278>

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэхээр батлах хууль тогтоомжийн явц, төлөв

- Монгол Улсын Их Хурлын тамгын газар, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа,УБ.,2017
- Монгол Улсын Их Хурлын тамгын газар, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар,УБ.,2019
- “Төрийн байгуулалтын байнгын хорооноос Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх цахим хэлэлцүүлгийг зохион байгууллаа”, мэдээ, <http://www.parliament.mn/n/hezon>
- “Төрийн байгуулалтын байнгын хорооноос Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх цахим хэлэлцүүлгийг зохион байгууллаа”, мэдээ, <http://www.parliament.mn/n/hezon>
- Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан, Б.Мягмарсүрэн, “Монгол Улсын Үндсэн хууль дахь Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх зохицуулалт ба хууль тогтоох байгууллагын оролцоог хязгаарлах механизмын зарим асуудал” эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл,УБ, 2021, <https://legaldata.mn/b/867>
- Төрийн мэдээлэл, 2020.06.23, №23 /1126/